

АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэсэн: Хууль зүйн ухааны доктор М.Уянга, Хууль зүйн ухааны доктор Б.Нинжин

Зөвлөх: Хууль зүйн ухааны доктор Э.Байгал

Улаанбаатар хот

2024 он

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЕХ	Европын Холбоо
ОХУ	Оросын Холбооны улс
CIETAC	Хятадын Олон Улсын Эдийн Засаг Худалдааны Арбитрын Комисс
DIS	Германы Арбитрын Хүрээлэн
DIS-Sport	Германы Спортын Арбитрын шүүх
ZPO	Герман улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
AAA	АНУ-ын Арбитрын холбоо
CAS	Спортын Арбитрын холбоо
UNCITRAL	United Nations Commission on International Trade Law

ГАРЧИГ

I. Удиртгал

II. Үндсэн хэсэг

A. Эх газрын орны холбогдох зохицуулалт

1. Арбитрын маргааны харьяалал болон төрөлжсөн арбитрын зохицуулалт
2. Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа
3. Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт
4. Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт
5. Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай зохицуулалт

B. Нийтлэг орны холбогдох зохицуулалт

1. Арбитрын маргааны харьяалал болон төрөлжсөн арбитрын зохицуулалт
2. Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа
3. Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт
4. Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт
5. Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай зохицуулалт

C. Хөрш орны болон хөгжиж буй орнуудын холбогдох зохицуулалт

1. Арбитрын маргааны харьяалал болон төрөлжсөн арбитрын зохицуулалт
2. Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа
3. Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт
4. Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт
5. Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай зохицуулалт

D. Харьцуулалтад хамаарах Монгол Улсын зохицуулалт

III. Дүгнэлт

IV. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал

I. Удиртгал

Монгол Улсад арбитрын үйл ажиллагааг зохицуулж буй Арбитрын тухай хууль / шинэчилсэн найруулга/ 2017 онд батлагдсан байдаг. Энэхүү хууль нь өмнө нь үйлчилж байсан 2003 оны Арбитрын тухай хуулийг өөрчилж, Олон улсын худалдааны комиссоос боловсруулсан Арбитрын загвар хуульд үндэслэгдэн боловсруулагдсан юм. Уг хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж эхэлснээс хойш Монгол Улсад МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитраас гадна хэд хэдэн байнгын арбитрын байгууллага байгуулагдаад ажиллаж байна. ШЕЗ-ийн арбитрын хэргийн талаар судалгааг үндэслэхэд тус хууль батлагдсанаас хойш 1000 гаруй хэрэг арбитрын байгууллагаар хянагдаж, шийдвэрлэгдсэн байв. Иргэний шүүхээр хянан шийдвэрлэж буй тоотой харьцуулахад арбитраар маргаанаа шийдвэрлүүлж байгаа нь харьцангуй бага хэвээр байна.

ХЗДХЯ-ны санаачилгаар 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтад заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийгдсэн бөгөөд тус судалгааны үр дүнд гарсан зөвлөмжид Арбитрын тухай хуульд зарим нэмэлт өөрчлөлт болон нэмэлт судалгаа хийхийг зөвлөсөн байгаа. Эдгээр зөвлөмжийг үндэслэж, үргэлжлэл болгож энэхүү судалгааг хийж байгаа болно.

Судлагдсан байдал

Монгол Улсын Арбитрын тухай хууль нь ерөнхий зорилгыг хүрээнд олон улсын стандартад нийцсэн хууль болсон гэж үнэлэгдсэн. Харин нарийвчилсан зарим зохицуулалтыг сайжруулах, нэмэлт өөрчлөлт хийн шаардлагатай гэж гарсан. Хэдий Арбитрын тухай хуулийн талаар өмнө нь хэд хэдэн судалгаа хийгдсэн байсан ч эдгээр нь хэрэгжилтийн үр нөлөөний талаар хийгдээгүй, анализ шинжилгээ нь хангалттай бус, гадаад орнуудын зохицуулалтыг хүүрнэсэн байдлаар авч үзсэн байв.

ХЗДХЯ-ны санаачилгаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдамж болгож Арбитрын тухай хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ хийгдсэн байдаг. Энэхүү судалгааны нь дараах асуудлыг авч үзсэн байв. Үүнд:

1. Арбитрын тухай хууль нь (2017) ЮНСИТРАЛ-ын загвар хуультай нийцсэн байдал
2. Байнгын болон байнгын бус арбитрын үйл ажиллагааны хэрэгжилт
3. Монгол Улс дахь байнгын арбитрын байгууллагын дүрэм, хуульд нийцсэн байдал
4. Арбитрын үйл ажиллагаа дахь шүүхийн оролцоо, тулгамдсан асуудал
5. Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйн асуудал
6. Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх асуудал зэрэг багтана.

Тус судалгааны хүрээнд Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд дараах дүгнэлтийг судлаачид тогтоосон:

1. Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд дараах зөвлөмжийг харгалзах, үүнд:
 - Спортын, хөдөлмөрийн зэрэг төрөлжсөн тусгай арбитрын үйл ажиллагааг ялгаатай зохицуулах. Ингэхдээ, Арбитрын тухай хуульд тусгайлсан зохицуулалт оруулах, эсвэл өөр тусгайлсан хуулиар (спортын тухай зэрэг) зохицуулдаг байх; Одоогийн хэрэгжиж буй Арбитрын тухай хуульд тусгайлсан арбитрын зохицуулалт багтаагүй байна.
 - Олон улсын ба дотоодын маргаанд ялгаатай хэрэг хянан шийдвэрлэх журам хэрэглэх талаар хуульд “арбитрын төрөл” эсвэл “арбитрын харьяаллын маргаан” хэсэгт тусгах тусгах;
 - Арбитрын үйл ажиллагаанд хамааралгүй, тухайлбал дампуурал зэрэг, асуудлыг хуулиас хасах;
 - Арбитрын тухай хуулийн 13.1.3-т заасан “*өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх*” шалгуурыг холбогдох хуулийн заалтуудаар дэлгэрүүлэх;
 - Арбитрын тухай хуулийн 14.2-т заасан арбитрчийг татгалзан гаргах “*хуулиар тогтоосон шаардлагад нийцээгүй*” байх шаардлагыг холбогдох хуулийн заалтуудаар тодорхойлох;

- Арбитрын тухай хуулийн 7.2, 13.4, 13.5 болон 16.1-д заасан “эрх бүхий этгээд”-д хэн багтах, арбитрын бүрэлдэхүүн багтах бол тэдгээрийн эрх хэмжээ зэргийг хуульчлах;
- Арбитрын хэргийн харьяаллыг олон улсын жишигт нь нийцүүлэн арбитрын хэлэлцээр, шүүхийн харьяалал зэргээр хязгаарлахгүйгээр салбар эрх зүй буюу “хувийн эрх зүйн” харилцаа байхыг тодотгох; Энэ нөхцөлд бусад тусгай арбитрын харьяаллыг өөр хуулиар зохицуулах мөн эд хөрөнгийн бус маргааныг хянан шийдвэрлэхгүй байх талаар тусгах;
- Арбитрын тухай хуульд арбитрын цахим процессын хүчин төгөлдөр байдлыг тусгах шаардлагатай ба дотоодын арбитрын байгууллагууд өөрсдийн журмаараа зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Зарим улсад улс хариуцагчаар орж байгаа маргааныг Арбитраар хянан шийдвэрлэхгүй байх талаар заасан байдаг тул энэ асуудлыг мөн хуулиар зохицуулан зааж өгөх (Казахстан улсын Арбитрын тухай хууль, 2016 он);
- Арбитрын ажиллагааны явцад тодорхой шийдвэрийг эрх бүхий этгээд болон шүүх гаргахаар зохицуулсан тул “эрх бүхий этгээд”-ийг тодорхойлох;
- Арбитрч нарт тавигддаг шаардлагыг насны хязгаарлалт, мэргэжил, салбартаа мэргэшсэн байдлын шалгуур зэргээр тогтоож олон улсын жишигт нийцүүлэх;
- Арбитрын бүрэлдэхүүний гарах шийдвэрийг зааглаж тодорхойлох, тухайлбал арбитрын ажиллагааны явцад гарах шийдвэр, эцсийн шийдвэрийн томъёоллыг тодорхойлох;
- Арбитрын танхим, холбоо байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; (Байнгын арбитрын байгууллагуудын үйл ажиллагааг хуульд нийцүүлэх, сургалт хийх, үйл ажиллагаанд нь мониторинг хийх);

Тус судалгааны үр дүнд гарсан зөвлөмж:

1. Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор гадаад орнуудын арбитрын тухай хуульд харьцуулсан судалгаа хийн, хэрхэн нэмэлт өөрчлөлт оруулах талаар дүгнэлт гаргах;
2. Арбитрын хэргийн харьяаллын талаар мөн бусад орны зохицуулалтыг харьцуулан судлах, ялангуяа онцгой маргаан шийдвэрлэдэг спортын, хөдөлмөрийн арбитр, улсын онцгой харьяалалд байдаг маргааныг хэрхэх талаар тусдаа судалгаа хийх;
3. Арбитрын хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулалттайгаар гүйцэтгэх. Тухайлбал, арбитрч, шүүгч нарыг мэргэшүүлэх, арбитрчийн мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, субъектив байдлаар жагсаалтад оруулах байдлыг багасгах зэргийг дурдаж болно.
4. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, дүрмийг олон улсын маргаан ба дотоодын маргаанаар зааглан зохицуулах, олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх;
5. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актыг “журам” гэж нэрлэн олон улсын стандартад нийцүүлэх. Үүнтэй холбоотойгоор, Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийг зөв тайлбарлаж хэрэглэх;
6. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байнгын арбитруудын дүрмийг Арбитрын тухай хуульд нийцүүлэх;
7. Онцгой, холимог эрх зүйн харилцааны маргааны шийдвэрлэдэг, олон улсын дүрмээр үйл ажиллагаагаа явуулдаг (Олон улсын спортын холбоо, байгууллагуудын хувьд) тусгай арбитрын зохицуулалтыг бусад улсын жишээ дээр харьцуулсан судалгаа хийх;
8. 8-р зүйлд дурдсан арбитрын холбогдох дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулахдаа арбитрчийг томилох, талууд тэгш эрх, хэрэглэх эх сурвалж, арбитрын ажиллагаа, гаргах бүхий л шийдвэр, эцсийн шийдвэрийн талаар зохицуулалтыг АтХ-д нийцүүлэх;
9. Арбитрын ажиллагааг арбитрын бүрэлдэхүүн өөрөө шууд хэрэгжүүлэх талаар, тухайлбал нотлох баримт цуглуулах, түр арга хэмжээ авах талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгөх;
10. Арбитрчийн ёс зүйн зөрчлийг хэрхэн шийдэх механизмыг хуульчлах, эсхүл арбитрын байгууллагын дүрмээр зохицуулах эрхийг хуулиар олгох;

11. Олон улсын жишгийг дагаад арбитрын ажиллагааны оролцогчдын ашиг сонирхлын зөрчлийг шалгах шалгуурыг илүү боловсронгуй болгох

Судалгааны үндэслэл: Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааны үр дүнд нэмэлт судалгаа хийх шаардлагатай болсон бөгөөд ХЗДХЯ-ны даалгаврын дагуу доорх хүрээнд судалгаа хийлгэх даалгавар өгсөн болно.

Судалгааны ажлын хүрээ, ажлын даалгавар:

- A. Арилжааны арбитраар хянан шийдвэрлэж буй хэрэг, харьяалал, бусад орнуудын арбитрын харьяалал, спортын болон бусад төрөлжсөн арбитрын зохицуулалт, харьцуулсан судалгаа
- B. Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт ялгаатай эсэх, тэр дундаа процессын болон бусад ялгаатай зохицуулалтыг хуульд хэрхэн тусгадаг тухай; Цаашлаад Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-р хэсэгт заасан харьяаллыг тодорхойлох;
- C. Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавих байгууллагууд, холбоо, ассоциацийн талаарх судалгаа
- D. Арбитрын ажиллагаанд шүүхийн оролцоо, хяналтыг багасгах үүрэгтэй оролцдог “эрх бүхий этгээд”-ийн ойлголтыг тодорхойлох стандарт, эрх үүргийн хязгаарлалт, бусад орны жишиг;
- E. Арбитрын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сонирхлын зөрчилдөөнийг бусад орны эрх зүйн орчныг зохицуулалтын үндсэн дээр харьцуулан судлах.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд хууль зүйн судалгааны хэд хэдэн аргыг хэрэглэхийн зэрэгцээ гол нь харьцуулсан судалгааны арга зүйг хэрэглэсэн. Ажлын даалгаварт заасан асуудлыг тодорхойлж, эрх зүйн бүлийн төлөөлөл болон хөрш орнуудын зохицуулалтыг харьцуулан судалж, ялгаатай байдлыг гол нь илрүүлж, манай орны холбогдох зохицуулалттай харьцуулж дүгнэлт гаргасан болно. Дүгнэлтийн үндсэн дээр

болон арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны дүнд үндэслэж Арбитрын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулсан.

II. Үндсэн хэсэг

Нийтлэг үндэслэл

1. Арбитрын харьяаллыг зөв тогтоох нь тухай арбитрын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэслэл болдог нь ойлгомжтой. Арбитрын төрлөөс хамаарч түүний харьяалал хамаардаг бөгөөд олон улсын хэмжээнд хөрөнгө оруулалтын маргааны арбитр, арилжааны буюу худалдааны арбитр, мөн дагнасан арбитууд үйл ажиллагаа явуулж байна.
2. Хөрөнгө оруулалтын арбитраар улс хариуцагчаар орох хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг авч хэлэлцдэг бөгөөд тухай арбитраар хэргээ хянан шийдвэрлүүлэх талаар хөрөнгө оруулалтын хэлэлцээр, ICSID-ын конвенц-аар загвар журмыг зохицуулсан байх жишээтэй.
3. Арилжааны буюу худалдааны арбитрын үйл ажиллагааг өнөөдөр дийлэнх улс нь НҮБ-ын ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэн олон улсын ба дотоодын маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэж, байнгын болон байнгын бус арбитрын хүрээнд хэрэгжүүлж байгаа.
4. Сүүлийн жилүүдэд дагнасан арбитууд байгуулагдах хандлага нэмэгдэж, спортын, оюуны өмчийн ба хөдөлмөрийн арбитууд холбогдох маргааныг шийдвэрлэж, салбарын загвар журам, өөрийн давж заалдах механизмтай болоод удаж байна.
5. Монгол улсын хувьд Худалдааны Арбитрын тухай хууль анх 1993 онд батлагдаж 2017 онд шинэчилсэн найруулгатай батлагдсан. Шинэчилсэн найруулга нь Арбитрын тухай хуулийг олон улсын жишиг, ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэх агуулгатай байв.
6. Арбитрын тухай хууль 2017 онд батлагдсанаас хойш Монгол улсад өнөөдөр Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, мөн төрөлжсөн арбитр болох Улаанбаатар хотын арбитр, Спортын олон улсын арбитр, Барилгын арбитр байгуулагдаж, Хөдөлмөрийн арбитрын эрх зүйн үндэс тавигдсан байна. Эдгээрээс өнөөдрийн байдлаар Барилгын арбитр үйл ажиллагаа явуулаагүй, Хөдөлмөрийн арбитрын журмыг нь Засгийн газрын тогтоолоор баталсан байдаг.

7. Монгол Улсад арбитрын үйл ажиллагааг бүхэлд нь Арбитрын тухай хуулиар зохицуулж байгаа нь дутагдалтай, төрөлжсөн буюу дагнасан арбитрын үйл ажиллагааны онцлогийг харгалзаагүй, холбогдох арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд хүндрэл үүсгэж, зөрчилдөөнтэй зохицуулалттай байна.
8. Манай улс нь Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай 1958 оны Нью Йоркийн конвенцод нэгдэн орохдоо нэмэлт тайлбар хийж, зөвхөн арилжааны буюу худалдааны маргааныг тус конвенцыг хэрэглэхээр заасан байдгийг дурдах нь зүйтэй.
9. Мөн түүнчлэн, Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам CAS буюу спортын олон улсын журам, давж заалдах процессын журамд нийцэх ёстой байтал 2017 оны Арбитрын тухай хуулийн буюу арилжааны арбитрын үйл ажиллагаанд чиглэгдсэн зохицуулагдах ёстой болоод байгаа.
10. Хөдөлмөрийн арбитрын хувьд Засгийн газрын .05.тоот тогтоолоор 2023 онд батлагдсан Хөдөлмөрийн арбитрын дүрмээр зохицуулагдаж, энэ нь арбитрын зарчим, арбитрын үйл ажиллагааны онцлогт нийцэхгүй байна гэж энэ багийн өмнө нь 2023 оны 6 дугаар сард хийсэн Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны үр дүнд тогтоогдсон юм.
11. Дээр дурдсан судалгааны явцад мөн өнөөгийн үйлчилж буй Арбитрын тухай хууль нь ЮНСИТРАЛ-ын загвар хуулийг ерөнхийд нь хуулбарласан, нутагшуулах зарим онцлогийг харгалзаагүй, байнгын арбитрын байгууллагууд арбитрын үйл ажиллагаатай холбоотой маргааныг таслах эрхийг хязгаарлагдмал байдлаар олгож, шүүхийн журмаар шийдвэрлүүлэх байдлыг нэвтрүүлж, мөн төрөлжсөн арбитрын онцлогийг харгалзаагүй, ЮНСИТРАЛ-ын зохицуулалтаар олгосон боломжийг бүрэн ашиглаагүй байна гэж дүгнэгдсэн юм.
12. Сүүлийн жилүүдэд байнгын арбитрын байгууллагууд нэмэгдэж байгаатай холбоотой тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах, арбитрын бүрэлдэхүүний чадвар, институтийн чадавхыг бэхжүүлэх тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой болоод байгаа.
13. Иймд энэхүү судалгааны хүрээнд Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны үр дүн, зөвлөмж болон дээр дурдсан үндэслэлийн хүрээнд гадаад орнуудын Арбитрын харьяаллын асуудал, мэргэжлийн холбоо,

арбитрын үйл ажиллагааны тогтолцоо, шүүхийн оролцоог хязгаарлах зохицуулалт, арбитрын мэргэжлийн ур чадварын дүрмийн талаар судлан авч үзлээ.

14. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ гол нь дээр дурдсанаар төрөлжсөн арбитуудыг хэрхэн зохицуулдаг, Арилжааны арбитрын харьяалалд нийтийн эрх зүйн маргаан хэрхэн хамаардаг, арилжааны болон захиргааны маргааны зааг хүрээг гадаад орнуудын холбогдох зохицуулалттай харьцуулан судалсан.
15. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Ром-германы болон Англо-саксоны бүлийн зарим орнууд, мөн хөрш орнуудын зохицуулалт, тухайлбал АНУ, Их Британи, Сингапур, ОХУ ба Европын Холбоо, тэр дундаа ХБНГУ, Унгар болон БНХАУ-ын холбогдох зохицуулалтыг харьцуулан судаллаа.
16. Арбитрын үйл ажиллагааг зохицуулахад удирдан хянадаг институтүүд, мэргэжлийн ур чадварыг хэрхэн зохицуулдаг талаар мөн олон улсын ба гадаад орнуудын арбитрын тухай хууль, журмыг харьцуулан авч үзсэн болно.

А. Эх газрын эрх зүйн тогтолцоотой орны холбогдох зохицуулалт

1. Европын Холбоонд (ЕХ) институтийн хувьд нэгдсэн тусгай арбитрын тухай хууль байхгүй ба гишүүн орнууд үүнийг үндэсний түвшинд дотоодын эрх зүйгээрээ зохицуулдаг. ЕХ-ны улс бүр өөрийн гэсэн арбитрын хууль тогтоомжтой байдаг бөгөөд энэ нь UNCITRAL-ийн Олон улсын арилжааны арбитрын тухай Загвар хуулийн хэлбэртэй байх нь элбэг.
2. Гишүүн орны зохицуулалтыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон Унгар улсын жишээ дээрээс дэлгэрэнгүй авч үзье. Энэ нь хөгжингүй болон хөгжиж буй орны зохицуулалтыг онцлогийн харуулах зорилготой юм. ХБНГУ-ын арбитрын тухай хуулийг Германы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10-р дэвтэрт (Zivilprozessordnung эсвэл ZPO) оруулсан болно. Энэхүү ИХШХШТХ-ийн 10-р дэвтэр нь UNCITRAL-ийн Олон улсын арилжааны арбитрын тухай Загвар хуулийг үндэслэснээр олон улсын стандартыг нийцүүлсэн жишээ юм.
3. Харин Унгар улсын арбитрын тухай зохицуулалт нь 1911 оноос эхлэлтэй бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд арилжааны арбитрын тогтолцоог анх нэвтрүүлжээ. Харин 2017 онд UNCITRAL-ийн Олон улсын арилжааны арбитрын тухай Загвар хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэх үүднээс шинэ хууль батлан 2018 оноос эхлэн Унгар улсын Арбитрын тухай хуулийг даган мөрдөж байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Арбитрын хэргийн харьяалал, төрөлжсөн арбитрауд

4. ХБНГУ-ын ZPO-ийн 1025-р зүйл нь хуулийн хамрах хүрээг заасан ба Герман улсын нутаг дэвсгэр дээр үүссэн арбитрын үйл ажиллагаанд шууд хэрэглэгдэхээр зохицуулжээ. Ингэхдээ, арилжааны эсвэл бусад төрөлжсөн хэмээн ялгаагүй нь арбитрын тухай зохицуулалтыг арилжааны болон бусад төрөлжсөн арбитрад “малгай” хэлбэрээр ашиглагдах боломжийг олгосон байна.
5. Төрөлжсөн арбитрын нэг болох спортын арбитрын хувьд, маргааныг ихэвчлэн мэргэшсэн арбитрын байгууллагууд шийдвэрлэдэг. Германд, Германы Спортын

Арбитрын шүүх (DIS-Sport) спортын маргаанд тусгайлан тохирсон дүрэм журмыг гаргадаг.

6. DIS-Sport зэрэг мэргэжлийн холбоод нь арбитрын хэлэлцээрийг спортын холбоодын дүрэм тусгасан байх бөгөөд тус холбоонд элссэнээр тамирчид болон бусад сонирхогч талууд арбитрын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрдөг байна. Харин ийнхүү байгуулсан арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдал, хэлбэр болон бусад зохицуулалт нь ZPO-ийн 1031-р зүйлд заасны дагуу шалгагдах бөгөөд хуульд заасан ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан байх ёстой.
7. Иймд, төрөлжсөн арбитрын дүрмийг мэргэшлийн хороод нь гаргах бөгөөд харин арбитрын хэлэлцээр зэрэг нийтлэг хууль зүйн асуудлууд нь арбитрын тухай хууль болох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10-р дэвтэрт тусгагдсан байна.
8. Цаашлаад, Германы Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1030 дугаар зүйл нь маргааныг арбитраар шийдвэрлэгдэх боломжийг зохицуулдаг. Уг зүйлд эд хөрөнгийн эрхэд хамаарах шаардлагыг арбитраар шийдвэрлэх боломжтой гэж заасан бөгөөд эд хөрөнгийн бус шаардлагыг талууд хувийн тохиролцоогоор шийдвэрлэх эрхтэй тохиолдолд мөн арбитрын гэрээнд хамруулах боломжтой байхаар зохицуулсан. Гэсэн хэдий ч, Германд орон сууцны түрээсийн харилцаатай холбоотой маргааныг арбитраар шийдвэрлэх гэрээ хүчин төгөлдөр бусд тооцогддог бөгөөд Иргэний хуульд заасан 549(2)-ийн 1-3 дугаар зүйлд тодорхойлсон түр оршин суух зэрэг тодорхой төрлийн орон сууцанд хамаарах тохиолдолд энэ нь үл хамаарна. Мөн уг заалтад арбитрын хүрээнээс гадуур байгаа бусад хууль тогтоомжийн хязгаарлалт, шаардлагыг хүлээн зөвшөөрч, зарим төрлийн маргааныг арбитраар шийдвэрлэхийг хязгаарлах эсвэл хориглох хууль тогтоомжийн хүчин төгөлдөр байдлыг харгалзах зохицуулалт багтжээ.

Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа

9. ХБНГУ-ын арбитрын тухай хууль нь арбитрыг байнгын болон байнгын бус хэмээн тусгайлан ангилдаггүй. Гэхдээ талуудын чөлөөт байдлын зарчимд үндэслэн

арбитрын журмыг тохирох боломжийг олгосон нь байнгын бус арбитр үйл ажиллагаа явуулах боломжийг давхар олгож байна.

10. Тухайлбал, Германы Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1042-р зүйл нь талуудад арбитрын ажиллагааг өөрсдийн сонгосон арбитрын дүрмийн дагуу эсвэл шууд тодорхойлох эрх чөлөөг олгодог.
11. Мөн ZPO-ийн 1034-р зүйл талууд арбитрчийг томилох арга, тэр дундаа түр арбитрт томилох журмыг өөрсдөө тодорхойлох талаар чөлөөтэй тохиролцох боломжтойг заасан. Иймд, ZPO-ийн 1034 (арбитрын бүрэлдэхүүний бүтэц), 1042 (арбитрын ажиллагааны журам) зэрэг заалтууд нь түр арбитрыг далд хэлбэрээр зохицуулсан гэж үзэж болохоор байна.

Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт

12. Германы Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь байнгын арбитрыг хянах эсвэл зохицуулах тодорхой байгууллагыг заагаагүй байдаг. Харин байнгын арбитр нь талуудын сонгосон арбитрын байгууллагуудын дүрэм, зохион байгуулалтын тусламжийг үндсэн дээр үйл ажиллагаа явуулж болно. Тухайлбал Германы Арбитрын Хүрээлэн (DIS) нь арбитрчийг томилох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах, маргаан шийдвэрлэх дүрэм санал болгох зэрэг үйлчилгээг бие даан үзүүлдэг. ZPO нь эдгээр байгууллагуудын бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, шууд төрийн хяналтын зохицуулалтыг тусгаагүй байна.
13. Арбитрын байгууллагууд үйл ажиллагаагаа бие даан явуулдаг хэдий ч ZPO нь арбитрын ажиллагааг дэмжих суурь зохицуулалтаар хангадаг ба үүнд шүүхийн оролцоо зүй ёсоор орно. Германы шүүхүүд арбитрчийг томилох (ZPO-ийн 1035 дугаар зүйл), нотлох баримт цуглуулах (ZPO-ийн 1050 дугаар зүйл), эсвэл шийдвэрийг хэрэгжүүлэх зэрэгт оролцдог. Мөн шүүхүүд талуудын хүсэлтийн дагуу арбитрын ажиллагааны шударга байдал болон нийтийн журмыг хангах зорилгоор ажиллагааг процессын талаас нь хянах боломжтой (ZPO-ийн 1059 дүгээр зүйл). Эдгээр заалтууд нь арбитрын үйл ажиллагааг зөв зохистой явуулахад тусалдаг ба арбитрын байгууллагуудын бие даасан байдлыг хадгалдаг.

14. Талууд DIS-ийн арбитрын дүрэм эсвэл ОУ-ын Арбитрын Танхим (ICC), Лондонгийн олон улсын арбитрын шүүх (LCIA) зэрэг олон улсын байгууллагуудын дүрэм зэрэг аливаа арбитрын байгууллагын журам ашиглахыг чөлөөтэй сонгох эрхтэй.

Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт

15. UNCITRAL-ийн Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийг үндэслэн дотоодын арбитрын хуулиа баталсан эх газрын эрх зүйн улс орнуудад “эрх бүхий байгууллага” гэдэг нэр томьёо нь арбитрын ажиллагаанд шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр чиглэгдсэн шүүх эсвэл төрийн тусгай байгууллагыг хэлнэ.
16. Эрх бүхий байгууллагын үүрэгт арбитрын үйл ажиллагааны явцад талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд арбитрчийг томилох, арбитрчийг татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэх, арбитрчийн бүрэн эрхийг дуусгавар болгох, нотлох баримт цуглуулах, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох, эсвэл хүлээн зөвшөөрч биелүүлэх зэрэг туслалцаа орно.
17. Эх газрын эрх зүйн улс оронд энэхүү эрх бүхий байгууллага нь арилжааны болон арбитрын асуудлаар мэргэшсэн шүүх байх нь элбэл. Жишээлбэл, ХБНГУ-д Дээд бүсийн шүүх (Oberlandesgericht) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу энэ үүргийг гүйцэтгэдэг. Үүний нэгэн адил Австри улсад Венийн Арилжааны шүүх (Handelsgericht Wien) эдгээр үүргийг хариуцдаг.
18. ХБНГУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1035-д арбитрчийг томилох журмыг тодорхойлсон бөгөөд ингэхдээ талуудын бие даасан байдлыг онцолжээ. Талууд арбитрчийг томилох журмын талаар чөлөөтэй тохиролцох боломжтой бөгөөд аль нэг тал арбитрчийг томилж, нөгөө талдаа мэдэгдсэн тохиолдолд уг томилгоо хүчинтэй болно.
19. Хэрэв талууд процессын талаар тохиролцож чадаагүй эсвэл тогтоосон хугацаанд арбитрчийг томилж чадаагүй бол шүүх арбитрын ажиллагааг үргэлжлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч арбитрчийг томилдог байна. Маргааныг ганц арбитрч шийдвэрлэх тохиолдолд шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрчийг томилдог.

20. Арбитрын байгууллагууд ихэвчлэн арбитрын хэлэлцээр эсвэл талуудын сонгосон дүрмийн дагуу арбитражийг томилдог. Жишээлбэл, талууд Германы Арбитрын хүрээлэн эсвэл Олон улсын худалдааны танхим зэрэг байгууллагын дүрмийн дагуу маргааныг шийдвэрлэхээр тохиролцсон тохиолдолд тухайн байгууллагад арбитраж томилох эрх мэдлийг далд хэлбэрээр шилжүүлдэг. Байгууллагын дүрэмд арбитражийг хэрхэн сонгох, талууд томилгоо хийгээгүй тохиолдолд тухайн байгууллага ямар арга хэмжээ авахыг тодорхойлсон нарийвчилсан заалтуудыг агуулсан байдаг.

Арбитражийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай зохицуулалтууд

21. Германы Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO) нь арбитражийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах үндсэн хуулийн орчныг бүрдүүлдэг. ZPO-ийн 1036 дугаар зүйлд арбитражийн хараат бус байдал, шударга ёс, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагыг тодорхой заасан. Энэ заалтын дагуу арбитраж нь хараат бус, аливаа талд ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой; ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй тохиолдолд арбитраж үүнийг нэн даруй мэдэгдэх үүрэгтэй; болон талууд арбитражийн хараат бус байдалд эргэлзээтэй гэж үзвэл ZPO-ийн дагуу арбитражийг татгалзуулах хүсэлт гаргах боломжтой.

22. Үүнээс гадна, байнгын арбитрын байгууллагын дүрэмд тусгаж өгсөн байна. Жишээлбэл, Германы Арбитрын Хүрээлэн (DIS) нь арбитражийн хараат бус байдал болон ёс зүйг зохицуулах дүрэм журамтай. DIS-ийн дүрэмд арбитражийн мэргэжлийн ур чадвар, туршлагын шаардлагуудыг тусгасан байх¹ бөгөөд ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд арбитражийг чөлөөлөх, сольж томилох механизм агуулжээ.²

Унгар улс

Арбитрын хэргийн харьяалал, төрөлжсөн арбитражууд

¹ DIS Arbitration Rules 2021, Article 7

² DIS Arbitration Rules 2021, Article 9

1. Унгар улсын Арбитрын хууль нь Унгар улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй арбитрын ажиллагаанд хамаарах бөгөөд хэрэглэгчийг хамгаалахтай холбоотой маргаан; иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7-р бүлэгт заасан тусгай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (гэр бүлийн эрх зүй, төрийн болон хувийн асран хамгаалагчийн асуудал, түүнчлэн хөдөлмөрийн болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны маргаан гэх мэт); болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хүрээнд хамаарах маргаанаас бусад иргэний эрх зүйн болон арилжааны маргаанд хамаардаг байна.³
2. Спортын болон бусад төрөлжсөн арбитрын тухайд, Унгар улсын Арбитрын хууль нь тусгайлсан зохицуулалт агуулаагүй ба спорттой холбоотой маргаанууд Спортын Арбитрын Шүүх гэх мэргэжлийн байгууллагыг харьяалалд багтдаг байна. Ингэхдээ спортын маргааныг олон улсын болон дотоодын гэж ангилдаг бөгөөд Унгар улсын нутаг дэвсгэр дээр явагдаж буй спортын маргааны хууль эрх зүйн нийтлэг зохицуулалт нь арбитрын тухай хуульд нийцсэн байна.
3. Унгар улсын арбитрын харьяалал нь газар зүйн шинж чанартай байгаа нь ХБНГУ зэрэг бусад эх газрын эрх зүйтэй орнуудтай төстэй байна.

Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа

1. Унгарын Арбитрын тухай хууль байнгын болон түр арбитрын аль алиныг нь хүлээн зөвшөөрдөг ба дараах зүйлүүдээр зохицуулсан байна.
2. Тухайлбал, хуулийн 1.2-т Унгар улсын нутаг дэвсгэр дээр явагдаж буй арбитрын үйл ажиллагаа нь байнгын эсхүл түр арбитр байхаас үл хамааран энэхүү хуульд хамаарна хэмээн заажээ. Цаашлаад, арбитрчийн хариуцлагын талаарх 57-р зүйлд арбитрчийг татгалзан гаргах дүрмийг байнгын арбитрын дүрэмд эсхүл түр арбитрт талуудын тохиролцсон журмын дагуу татгалзан гаргаж болно гэж заажээ.
3. Арбитрын зардлыг тооцох тухай 62-р зүйлд түр арбитрын зардлыг талууд болон арбитрын бүрэлдэхүүн харилцан тохиролцож шийдвэрлэх талаар мөн оруулсан

³ Унгар улсын Арбитрын тухай хуулийн 1-р зүйлийн 3 дахь хэсэг

байна. Энэ мэтчилэн зохицуулалтыг шигтгэж өгсөн нь байнгын болон түр арбитрыг хүлээн зөвшөөрдгийн илрэл болж байна.

Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт

1. Унгар улсад арбитрын ажиллагааг хянадаг тусгай төрийн байгууллага байдаггүй ч, арбитрын үйл ажиллагааг зохицуулах болон хянах үүргийг тодорхой байгууллагууд гүйцэтгэдэг. Тухайлбал, дараах байгууллагуудыг дурдаж болно.
2. Арбитрын байгууллагууд: Унгар улсад арбитр нь голчлон Унгар улсын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Арбитр эсвэл Байнгын Худалдааны Арбитрын Шүүх гэх мэргэжлийн арбитрын байгууллагуудын удирдлага дор явагддаг. Эдгээр байгууллагууд нь өөрсдийн дүрэм, журмыг боловсруулж, арбитрын ажиллагааг удирддаг. Гэхдээ эдгээр нь зохицуулах байгууллагууд биш, харин арбитрын ажиллагааны хэвийн гүйцэтгэлийг хариуцдаг байгууллагууд юм.
3. Унгар Улсын Хууль зүйн яам: Унгар Улсын Хууль зүйн яам нь арбитрын хууль, тогтоомжийн хүрээнд зөвлөмж өгөх үүрэгтэй. Энэ хүрээнд яам нь Унгар улсын Арбитрын Хуулийг олон улсын стандарт болон гэрээнүүдтэй нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй бөгөөд тухайн хуулийн дагуу арбитрын үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгааг хянахад оролцдог. Гэвч энэ яам нь шууд арбитрын үйл ажиллагааг хянахгүй.
4. Шүүхийн хяналт: Унгар улсад арбитрын үйл ажиллагаанд тусгай хяналтын байгууллага байхгүй. Гэвч Унгар улсын шүүхүүд арбитрын ажиллагаанд тодорхой хэмжээгээр хяналт тавьдаг. Жишээлбэл, талууд арбитрын ажиллагааны явцад үүссэн аливаа маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр хандаж болдог. Унгар улсын шүүхүүд нь арбитрын гэрээний хүчин төгөлдөр байдал; арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал зэргээр шийдвэр гаргах эрхтэй.
5. Арбитрын ажиллагааны эрх бүхий этгээд ч мөн адил шүүхээс гадна дээр дурдсан байгууллага байх боломжтой. Үүнийг талууд харилцан тохирох боломжтой юм.

Б. Англо-саксоны эрх зүйн тогтолцоотой орны холбогдох зохицуулалт

Арбитрын хэргийн харьяалал, төрөлжсөн арбитраар

1. Англо-саксоны тогтолцоотой орнуудад арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл нь талууд арбитрын хэлэлцээр бөгөөд арбитрын харьяалалд арилжааны маргаан болон бусад маргаан гэж ангилсан онцлогтой байна. Арилжааны маргааны хувьд ихэнх улс нь НҮБ-ын ЮНСИТРАЛ-ын загвар хууль болон Гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай 1958 оны НҮБ-ын конвенцыг баримталжээ.
2. АНУ-д арбитрын үйл ажиллагаа нь бүр дундад зуунаас эхлэлтэй бөгөөд тухайн цаг үеэсээ хамаарч, хүлээн зөвшөөрөгдөх байдал нь ялгаатай байж ирсэн. Тухайлбал аж үйлдвэрийн хувьсгалын үеэр худалдаачид зардал ихтэй арбитраар эсэргүүцэж байгаад 20 дугаар зууны эхэн үеэр арбитр илүү дэмжигдэх болсон. 1920 онд Нью Йоркийн Арбитрын хууль, Холбооны арбитрын хууль⁴ 1925 онд батлагдсан байдаг.
3. Худалдааны буюу арилжааны арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхэд талууд хамгийн гол нь арбитрын хэлэлцээр байгуулах ёстой байж, арбитрын шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелүүлэгдэх шинжтэй юм. Худалдааны арбитр нь тухайн маргаан нь арбитраар харьяалагдах эсэх, шүүхэд харьяалагдах эсэхийг шалгадаг. Зарим маргааныг арбитраар шийдвэрлүүлэхийг зөвшөөрдөггүй бөгөөд АНУ-ын мужийн шүүхэд эрүүгийн хэрэг, гэр бүлийн маргааныг шүүхээр шийдвэрлэхийг хуульчилсан байдаг байна.
4. АНУ-д хөдөлмөрийн зарим маргааныг арбитраар шийдвэрлүүлэхийг зөвшөөрдөг бөгөөд үүнд нэгт, шинэ гэрээнд тусгах нөхцөлийг арбитраар шийдүүлэх, хоёрт хамтын хэлэлцээртэй холбоотой маргааныг шийдүүлж болдог байна. Гэхдээ энэ нь тусдаа зохицуулалттай, Үндэсний хөдөлмөрийн холбоо нь арбитраар хөдөлмөрийн бусад маргааныг шийдүүлж болно⁵ гэжээ.
5. Тус улсад мөн хувьцаатай холбоотой маргааныг арбитрын шүүхэд тухайлбал брокерын компани ба үйлчлүүлэгчийн хооронд маргааныг шийдүүлж болдог байна.

⁴ <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2019-title9/html/USCODE-2019-title9.htm>, Federal Arbitration act, 1925

⁵ <https://www.adr.org/sites/default/files/LaborRules-Web.pdf>, Америкийн арбитрын холбооны вэб хуудас дахь дүрэм

Санхүүгийн салбарын зохицуулах газрын хүрээнд энэ төрлийн үйл ажиллагааны арбитрыг зохицуулдаг⁶ онцлогтой байв.

6. АНУ-ын Холбооны арбитрын тухай 1925 оны хууль нь холбооны болон мужийн арбитраг хамаарах бөгөөд гэрээний холбоотой маргааныг шийдвэрлэхээр зохицуулж, зарим нэгэн салбарыг өөрийн харьяаллаас хассан. Тухайлбал далайн тээвэр, төмөр замын тээврийн ажилчидтай байгуулах гэрээ, гадаадын аж ахуйн нэгжийн ажилчдын холбоотой гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэхгүй гэжээ.
7. АНУ-ын Холбооны Арбитрын тухай хуулийн 1 дүгээр зүйлд далайн хэлцлийг энэ хуулиар зохицуулахгүй бөгөөд тус хуульд муж хоорондын болон бусад гадаад улстай байгуулсан арилжааны хэлцлүүд энэ хуульд хамаарахгүй гэж заасан байв. Мөн тус хуульд далайн ажилчдын, төмөр замын ажилчид болон гадаад болон улсын хоорондын аж ахуйн нэгжийн ажилчдын хоорондын гэрээ нь энэ хуульд хамаарахгүй гэжээ.
8. Спортын арбитрын хувьд олон улсын спортын холбоод холбогдох холбоо⁷ болон Олон улсын спортын арбитрын шүүхийн дүрэмд тус тус үндэслэдэг байна.
9. АНУ-ын хувьд спортын арбитраг холбоотой олимпын, спортын байгууллагын оролцогчид, спортын байгууллагын франчайз болон допингийн маргаантай холбоотойгоор тусгайлсан хууль үйлчилдэг байна. Тухайлбал АНУ-д Ted Stevens Olympic and Amateur Sports Act of 1978 and the U.S. Olympic Committee (USOC) -ийн дотоод дүрэмд заасны дагуу спортын холбоотой маргааныг шийдвэрлэх талаар зохицуулсан байна. Үүнийг үндэслэхэд АНУ-д спортын арбитрын тухай зохицуулалт нь тусдаа АНУ-ын Олимпын хороо, АНУ-ын допингийн эсрэг агентлаг холбогдох маргааныг шийдвэрлэдэг байна. АВА буюу АНУ-ын Арбитрын холбоо⁸ нь тус улс дахь арбитрын үйл ажиллагааг хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдгийн хувьд спортын арбитрын төрөлжсөн байгууллагууд, жишээ нь гольфийн арбитрын байгууллагуудад арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулдаг байна.

⁶ Doss, Jason R.; Frankowski, Richard S. (2013). *The Practitioner's Guide to Securities Arbitration*. Chicago: American Bar Association. p. 17. ISBN 9781614387596.

⁷ <https://www.usopc.org/governance/dispute-resolution>

⁸ https://go.adr.org/sports-dispute-resolution.html?utm_source=website&utm_medium=click&utm_campaign=sports-dr

10. Хөдөлмөрийн арбитрын хувьд тусдаа зохицуулалттай Үндэсний хөдөлмөрийн хороо нь хөдөлмөрийн маргааны арбитрын загвар журмыг боловсруулсан байх жишээтэй.
11. АНУ-ын Арбитрын холбооны веб хуудаст ороход төрөлжсөн арбитрын загвар журмыг танилцуулсан байна. Жишээлбэл хөдөлмөрийн холбоотой маргаан, хэрэглэгчийн маргаан, арилжааны маргааны болон барилгын арбитрын маргааны зохицуулалтыг заасан байна.

Их Британи улс

12. Их Британи улсын Лондоны арбитрын шүүх нь олон улсын арилжааны маргаан шийддэг нэр хүндтэй арбитрын нэг юм. Гэрээний болон гэрээний бус үүрэгтэй холбоотой нэхэмжлэлийг арилжааны арбитраг гаргаж болох бөгөөд үүнд оюуны өмч, өрсөлдөөний зарим асуудал багтдаг байна. Харин эрүүгийн болон гэр бүлийн эрх зүйн асуудлыг арбитраг шилжүүлж болохгүй юм. Их Британи улсад арбитрын үйл ажиллагааг зохицуулсан гол хууль нь 1996 оны Арбитрын тухай хууль⁹ байдаг бөгөөд түүний үйлчлэх хүрээнд олон улсын ба дотоодын маргаан шийддэг Их Британид үйл ажиллагаа явуулдаг арбитраг хамаардаг юм.
13. Их Британийн 1996 оны Арбитрын тухай хуулийн 81 (1) (а)-д арбитраг хамаарах маргааныг зааж өгөөгүй боловч тус улсын шүүх хэрэг тус бүр дээр арбитрын харьяаллыг шийднэ гэжээ. Англо-саксоны тогтолцоотой тус орны хувьд арбитрын харьяаллыг тогтооход шүүхийн жишиг чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүний нэгж жишээ нь (Fulham Football Club (1987) Ltd v Richards [2011] EWCA Civ 855, para 40) хэрэгт нийтийн ашиг сонирхлын маргааныг арбитраг шийдэх боломжгүй гэж шийдсэн байна.
14. Тус улсад харин оюуны өмч, хөдөлмөрийн маргаан болон хэрэглэгчийн эрх, өрсөлдөөний холбоотой маргааныг арбитраг шийдүүлэхийг зөвшөөрдөг бөгөөд харин компанийн дампуурлын асуудлыг арбитраг шийдүүлэх боломжгүй гэжээ.
15. Их Британи улсад арилжааны дараах арбитрын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Олон улсын арбитрын Лондоны шүүх

⁹ <https://www.legislation.gov.uk/ukpga/1996/23/data.pdf>, UK Arbitration act 1996

Арбитрчийн нэгдсэн хүрээлэн

Лондоны далайн арбитр¹⁰

16. АНУ, Их Британи улсад аль алинд нь арбитрын үйл ажиллагаатай холбоотой зарим асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой байгаад байна. Гол төлөв энэ нь арилжааны арбитраж хамаараад байна. Гэхдээ АНУ-ын Арбитрын тухай хуульд тус хуулийн үйлчлэх хүрээ, хязгаарлалтыг бүр нарийн заагаагүй боловч агуулгыг харахад тус хууль нь арилжааны арбитраж хамаараад байна.
17. Төрөлжсөн арбитрын хувьд мөн арилжааны арбитраас тусдаа зохицуулалт үйлчилдэг.
18. Sport resolutions буюу Спортын зөвшилцөл байгууллага¹¹ нь спортын маргаан шийдвэрлэх арбитр болон зуучлалын үйлчилгээ үзүүлдэг бөгөөд дэргэд нь Олон улсын хянан шийдвэрлэх хуралдаан, Үндэсний допингийн эсрэг хуралдаан болон үндэсний хамгаалалтын хуралдаан ажилладаг. Түүнчлэн олон улсын олимпын хорооны байгуулсан Олон спортын арбитр мөн маргаан шийдвэрлэх үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Хувийн хуулийн компаниуд болох **Walker Morris, CMS Law** нь спортын маргааныг шийдвэрлэх үйлчилгээ үзүүлдэг.¹²

Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа

19. Англо саксоны орнуудад байнгын болон байнгын бус арбитрын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг бөгөөд байнгын арбитрын хувьд тухайн арбитрын төрлөөс хамаарч өөрийн дүрэм журмаа тогтоодог. Байнгын арбитрын хувьд олон улсын загвар дүрэм болон өөрийн үндэсний хэмжээний дүрэм батлагдсан байдаг. Байнгын арбитражуудын талаар дээр дурдсан тул энэ хэсэгт давтаагүй.
20. Гадаадын зарим орнуудад байнгын бус арбитрын тогтолцоо нэлээд нэвтэрсэн байдаг бөгөөд холбогдох хуулиар нь мөн зөвшөөрдөг. Байнгын бус арбитрын үйл ажиллагаа нь АНУ-ын арбитрын тухай хуульд зааснаар арбитрын хэлэлцээрт

¹⁰ <https://www.judiciary.uk/courts-and-tribunals/business-and-property-courts/commercial-court/the-work-of-the-commercial-court/the-commercial-court-and-arbitration/>

¹¹ https://www.sportresolutions.com/assets/documents/D_3_-_Arbitration_Rules_Nov_24.pdf

¹² Их Британид Спорт резолюшн болон Олон улсын олимпын хорооны спортын арбитр CAS-ийн хүрээнд маргаанаа шийдүүлж болдог.

үндэслэдэг бөгөөд талууд арбитрын хэлэлцээрт аль арбитраар шийдвэрлүүлэхийг заадаг. Арбитрын тухай Монгол улсын хуульд зааснаас ялгаатай нь арилжааны маргааны харьяаллыг зааж, зарим хамаарахгүй арилжааны маргааныг тусгаж, харин бусад арбитрын талаар зохицуулаагүй, мөн байнгын болон байнгын бус арбитр гэж ангилан зохицуулаагүй байв. Иймд арбитрын ажиллагааг эхлүүлэх гол үндэслэл нь арбитрын хэлэлцээр байж, талууд өөрсдөө арбитрчаа сонгож томилох тогтолцоотой байна.

21. Их Британи улсын арбитрын тухай 1996 оны хуульд мөн адил арбитрын хэлэлцээрийг үндэслэж талууд арбитраа сонгох эрхийг олгож, тус хуульд үйлчлэх хүрээг нарийн зааглаагүй. Иймд тус хуулийг үндэслэхэд байнгын бус арбитрт мөн энэ хууль үйлчилж, арбитрч томилох эрх болон арбитрчаа сонгох эрх нь хадгалагдаж байна. Талууд өөрсдөө арбитрын үйл ажиллагааны зарчимд үндэслээд

Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт

22. АНУ болон Их Британи аль улсад нь арбитрын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зангиддаг, арга зүйн хувьд хяналт тавьдаг, арбитрын үйл ажиллагааг хөгжүүлэх боловсронгуй болгох чиглэлээр Арбитрын холбоод ажиллаж байна. Жишээлбэл АНУ-д Америкийн арбитрын холбоо англиар AAA буюу Америкийн арбитрчийн холбоо¹³, Их Британи улсад Арбитрчийн нэгдсэн институт, англиар Ciarb буюу Chartered institute of Arbitrators¹⁴ ажиллаж байна. Спортын хувьд харин онцлог олон улсын олимпын хороо болон үндэсний холбоонд арбитрын зохицуулалт нь хамаарч тусдаа зохицуулалттай байна.

Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт

23. Англо-саксоны орнуудад Арбитрын тухай хуульд нь зааснаар хэрэв талууд харилцан өөрөөр тохиролцоогүй бол шүүхээр шийдвэрлүүлж болох зүйлийг заасан байдаг. Эдгээр орнуудад заавал баримтлах болон заавал баримтлах албагүй заалтыг ангилан

¹³ <http://www.adr.org>, American arbitration association

¹⁴ <https://www.ciarb.org>, Chartered Institute of Arbitrators, UK.

заасан байх жишээтэй. Тухайлбал Их Британийн Арбитрын тухай хуульд нь заавал баримлахгүй байж болох зүйлд арбитрын үйл ажиллагаатай холбоотой шүүхээр шийдвэрлүүлж болох асуудлыг заасан байна. Эдгээрийг дурдвал:

- Тухайн маргаан нь арбитрын хэлэлцээрт хамаарсан эсэх, 9-11 р зүйл
- тодорхой тохиолдолд арбитрчийг шүүхээр татгалзан гаргуулах, 24 -р зүйл
- арбитрч болон арбитрын байгууллагын халдашгүй байдалтай холбоотой эрх хэмжээ, 29,74 -р зүйл
- бүрэлдэхүүний шударгаа болон хараат бус байдлаар хэргийг шийдсэн талаар, 33-р зүйл
- арбитрын ажиллагааг зохих ёсоор болон түргэн шуурхай шийдэх арга хэмжээ авсан талаар талуудын үүрэг, 40-р зүйл
- гэрчийг оролцуулах талаар, 43-р зүйл
- талууд хураамж, зардлаа төлөөгүй нөхцөлд арбитр шийдвэр гаргах байх талаар, 56-р зүйл
- арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон хүчингүй болгуулах талаар, 66-71-р зүйлд тус тус заасан байна.

24. АНУ-д мөн Арбитрын тухай хуульд нь зааснаар шүүх арбитрын үйл ажиллагаанд оролцож болох талаар заасан байна. НҮБ-ын Арбитрын загвар хуульд зааснаар шүүх арбитрын ажиллагаатай холбоотойгоор талуудын хүсэлтийг үндэслэж шийдвэр гаргах эрхтэй байдаг байна. Энэ нь тус хуулиар байнгын болон байнгын бус арбитрын үйл ажиллагааг давхар зохицуулж байгаатай холбоотой гэж дүгнэж болох юм. Хамгийн гол нь талуудад шүүхэд хандах эрх нь байна гэдгийг хуульчилсан байв.

25. Англо-саксоны тогтолцоотой орнуудад аль алинд харин холбогдох талууд байнгын үйл ажиллагаа явуулдаг олон улсын арбитрын байгууллагын хүрээнд дүрэм, журмын дагуу маргаанаа шийдүүлэхээр тохиролцсон бол холбогдох журам дүрэмд заасны дагуу арбитрын ажиллагаа, шийдвэрийн талаар гарсан маргааныг шийдүүлэх тогтолцоог баримталдаг байна.

Мэргэжлийн ёс зүй, арбитрч нарт тавигдах шаардлага

26. АНУ-д Арбитрч болоход бакалаврын зэрэглэлтэй байж, маргаантай холбоотой салбараар мэргэшсэн байхыг шаарддаг байна. Арбитрч болоход тусгай зөвшөөрөл шаарддаггүй боловч зарим мужид нь салбараар мэргэшсэн байх, сургаалтанд суухыг шаарддаг.
27. АНУ-д төрөлжсөн арбитрагт арбитрагч нарт тусгай шаардлага тавьж болох бөгөөд холбогдох холбоо нь ёс зүйн дүрмээ баталсан байдаг. Тухайлбал АНУ-ын Арбитрын холбоо нь арбитрагч нарын ёс зүйн дүрмийг 2004 онд баталсан байдаг.¹⁵ Тус дүрэм нь хөдөлмөрийн арбитрагч нараас бусад арбитрагч нарт хамаарна гэжээ. Хөдөлмөрийн арбитрагч нарын хувьд тусдаа дүрэм Code of Professional Responsibility for Arbitrators of Labor-Management Disputes -д зааснаар зохицуулагддаг байна.
28. Арбитрын ёс зүйн дүрэмд нь зааснаар арбитрагчид заавал хуульч байхыг шаарддаггүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцохдоо хараат бусын мэдэгдэл, талуудаас хамааралтай байхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээд байх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг журамд заасны дагуу хэрэгжүүлэх чадвартай байх шаардлага тавьсан байна.
29. Холбогдох хэрэгт томилогдсон арбитрагч хараат бус байдлын мэдүүлэг өгч, мөн хэрэг хянан шийдвэрлэх явцдаа түүний хараат бус байдалд нөлөөлөх үйл ажиллагаанд оролцохгүй байх талаар заасан байдаг байна. Арбитрагийн ёс зүйн дүрэмд арбитрагчид хориглох зүйлийг дэлгэрэнгүй заасан байв.Талууд мөн гэрээндээ арбитрагчид тавигдах шаардлагыг тавьж тогтоож өгөхийг зөвшөөрдөг онцлогтой.
30. Арбитрын ёс зүйн дүрмээс харахад гол шаардлага нь салбараар мэргэшсэн, хараат бус байх болон хэрэг хянан шийдвэрлэх мэдлэгтэй байхыг шаардсан бөгөөд үүнээс өөр нэмэлт шаардлага тавиагүй байгаа нь манай улсын Арбитрын тухай хуулиас ялгаатай байв.
31. Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх арбитрын хувьд Code of Professional Responsibility for Arbitrators of Labor-Management Disputes нь 1974 онд батлагдсан бөгөөд тус төрлийн маргааныг хянан шийдвэрлэх арбитрагч нарт тавигдах шаардлага болон ёс зүйн дүрмийг нь заасан байдаг. Тус Дүрмийн 1 дүгээр заалтад зааснаар

арбитрч нь шударга, ёс зүйтэй болон хөдөлмөрийн маргаан шийдэх туршлагатай байх ёстой юм.¹⁶Бусдаар бол арбитрач нарт тавигдах шаардлага, хараат бусын байдал, талуудтай хамааралтай байхад тавигддаг шаардлага нь зарчмын хувьд нийтлэг байв.

С. Хөрш орны болон хөгжиж буй орнуудын холбогдох зохицуулалт

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Арбитрын маргааны харьяалал болон төрөлжсөн арбитрын зохицуулалт

1. 1994 онд батлагдсан БНХАУ-ын Арбитрын тухай хууль нь арбитрын маргааныг зохицуулах үндсэн хууль бөгөөд арбитрын байгууллага, процесс, арбитрачийн үүрэг хариуцлага, ёс зүйн талаар тодорхой заалтуудыг агуулдаг.
2. Арбитрын тухай хуулийн 2-р зүйлд эдийн засгийн болон гэрээний маргаануудыг арбитрын замаар шийдвэрлэх боломжтойг заасан бөгөөд энэ нь талуудын хооронд байгуулсан арбитрын гэрээний үндсэн дээр хэрэгждэг. Тус зүйлд, эдийн засгийн шинжтэй гэрээний болон бусад эрх зүйн маргааныг арбитрын ажиллагаанд хамруулж болохыг тодорхойлсон. Гэхдээ 3-р зүйлд зарим төрлийн маргааныг арбитраар шийдвэрлэх боломжгүйг дурдсан байдаг. Тухайлбал, гэр бүлийн харилцаа, залгамжлалтай холбоотой маргаан болон захиргааны шинжтэй маргаануудыг арбитрын хүрээнд шийдвэрлэхийг хуулиар хориглодог. Энэ нь арбитрын процессын хязгаарлалтыг тодорхойлж, арбитрын замаар шийдвэрлэх боломжтой маргааны хүрээг нарийвчлан тогтоосон зохицуулалт юм.
3. Спорт зэрэг төрөлжсөн арбитрын маргааныг олон улсын ба дотоодын хэмээн ангилан үздэг байна.
4. Хятадын Олимпын хороо (COC)¹⁷ эсвэл Спортын арбитрын шүүх (CAS)¹⁸ нь олон улсын спортын маргаан шийдвэрлэдэг бөгөөд арбитрын тухай хуулиар

¹⁶

https://www.adr.org/sites/default/files/document_repository/Code%20of%20Professional%20Responsibility%20for%20Arbitrators%20of%20Labor-Management%20Disputes_0.pdf

¹⁷ Chinese Olympic Committee

¹⁸ Court of Arbitration for Sport

зохицуулагддаггүй, олон улсын арбитрын зарчимд нийцсэн өөрийн дүрмийн дагуу ажилладаг.

5. Харин дотоодын спортын арбитрын тухайд арбитрын тухай хуульд спортын маргаантай холбоотой тодорхой эрх зүйн орчин байхгүй ч талууд дотооддоо арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцсон тохиолдолд эдгээр маргааныг шийдвэрлэхдээ Арбитрын тухай хуульд заасан зарчмыг баримтална.
6. Цаашлаад, БНХАУ дахь спортын арбитр нь БНХАУ-ын Спортын тухай хууль болон спортын захиргааны байгууллагаас гаргасан дүрэм журмын дагуу ажилладаг буюу өөрсдийн төрөлжсөн мэргэжлийн байгууллагад хамаардаг байна.

Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт

7. БНХАУ-ын хуулийн дагуу арбитрын шүүхийн стандарт хэлбэр нь байнгын арбитр юм. Арбитрыг хүлээн зөвшөөрөгдсөн арбитрын байгууллагын ивээл дор явуулах шаардлага хуульд тусгагдсан байдаг.
8. БНХАУ-ын Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйл арбитрын хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй арбитрын холбоодыг байгуулахыг шаарддаг. Эдгээр холбоодыг ихэвчлэн хотын захиргаа, худалдааны байгууллага эсвэл худалдаа, аж үйлдвэрийн танхимууд байгуулдаг бөгөөд албан ёсоор бүртгүүлж, хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.
9. Цаашлаад, 16-р зүйлд хүчин төгөлдөр арбитрын хэлэлцээрт арбитрын байгууллагыг тодорхой зааж өгөх ёстойг тусгасан. Хэрэв гэрээнд тодорхой арбитрын байгууллагыг заагаагүй эсвэл тодорхой бус заасан бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэхээр зохицуулжээ. Энэ нь байнгын арбитр нь арбитраар маргаан шийдвэрлүүлэх үндсэн арга болохыг харуулж байна.
10. Хятадын томоохон арбитрын холбоод Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын хороо (CIETAC), Бээжингийн арбитрын комисс (BAC), Шанхайн олон улсын арбитрын төв (SHIAC) зэрэг багтдаг.
11. БНХАУ-ын Арбитрын хуулийн дагуу байнгын бус арбитрыг зөвшөөрдөггүй. Арбитрыг хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан, хүлээн зөвшөөрөгдсөн арбитрын комиссын хяналтын дор явуулахыг хуульд заасан байдаг.

12. Гэхдээ тус хуульд 73 дугаар зүйлд олон улсын шинж чанартай маргааныг байнгын бус арбитраар шийдвэрлүүлж болох тухай онцгой тохиолдлыг дурджээ. Эдгээр тохиолдолд арбитраын хэлэлцээрт байнгын бус арбитраг тусгайлан дурдсан байх шаардлага тавигдсан. Гэсэн хэдий ч, уг хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдлыг шүүхээр хянах боломжтой тул хэрэгжих та дээр хүндрэлтэй байж болзошгүй юм.

Арбитраын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт

13. Хятадын Арбитраын тухай хуулийн дагуу арбитраын үйл ажиллагаанд хяналт тавьдаг гол байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн арбитраын холбоод юм. Эдгээр холбоодыг Хятадын засгийн газрын орон нутгийн захиргааны байгууллагууд, худалдааны танхимууд эсвэл мэргэжлийн холбоодын санаачилгаар байгуулахаар заасан байдаг. Тэдгээрийн зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлох эрх зүйн үндсийг Арбитраын тухай хуулийн 10-р зүйл-д тусгасан байдаг.
14. Эдгээр холбоод нь тухайн орон нутгийн захиргаа, худалдааны танхимууд эсвэл төрөлжсөн мэргэжлийн холбоодоос байгуулагдах бөгөөд үүрэг, зохион байгуулалтын талаар тус хуулийн 10-р зүйлд тодорхой заасан байдаг. Арбитраын комиссуудын үндсэн үүрэг нь маргаан хүлээн авах, арбитрач томилох, арбитраын ажиллагааг зохион байгуулах бөгөөд энэхүү явцад үйл ажиллагааны журамд нийцүүлэн шударга, хараат бус байдлыг хангаж ажилладаг.
15. Арбитраын холбоод нь арбитрачийн хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчлийг хянан ёс зүйн шаардлагыг сахиулдаг. Үүнээс гадна, арбитраын үйл ажиллагаанд засгийн газрын зарим байгууллага, мэргэжлийн холбоо оролцдог. Жишээлбэл, Худалдааны яам гадаад худалдааны маргаантай холбоотой бодлогыг тодорхойлох үүрэгтэй бол БНХАУ-ын Олон Улсын Эдийн Засаг, Худалдааны Арбитраын Хүрээлэн (СИЕТАС) нь олон улсын худалдааны маргаан хянан шийдвэрлэхэд онцгой үүрэгтэй байгууллага юм. Эдгээр зохицуулалтууд нь арбитраын ажиллагааны чанар, хараат бус байдал, шударга байдлыг хангахад чиглэгдсэн юм.

Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт

16. БНХАУ-ын Арбитрын тухай хууль-ийн дагуу арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд” нь арбитрын комисс болон арбитрын ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй бусад байгууллагуудыг хэлнэ. Тус хуульд “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт болон тэдгээрийн эрх, үүрэг, хязгаарлалтыг тодорхой заасан бөгөөд эдгээр нь арбитрын ажиллагааны хараат бус байдал, шударга байдлыг хангахад чиглэгддэг.
17. Арбитрын тухай хуулийн 10-р зүйл-д зааснаар арбитрын комисс нь тухайн орон нутагт засгийн газар, худалдааны танхим эсвэл мэргэжлийн байгууллагуудаас байгуулж болох бөгөөд арбитрын маргаан шийдвэрлэх, арбитрчийг томилох, талуудын маргааныг зохион байгуулах үндсэн үүрэгтэй. Арбитрын комисс нь талуудын тохиролцоонд үндэслэн арбитрчийг сонгох, эсвэл шаардлагатай тохиолдолд өөрсдөө арбитрчийг томилох эрхтэй. Гэсэн хэдий ч эдгээр үйл ажиллагаа нь зөвхөн талуудын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд явагдах ёстой бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс зайлсхийх үүрэгтэй.
18. Мөн 16-р зүйлд зааснаар арбитрын хэлэлцээр хүчинтэй байхын тулд арбитрын комисс зайлшгүй тодорхойлогдсон байх шаардлагатай бөгөөд эс тэгвээс хэлэлцээр хүчин төгөлдөр бус гэж үзэгдэнэ. Үүнээс гадна, 34-р зүйл-д арбитрын ажиллагааны шударга, хараат бус байдлыг хангахын тулд арбитрчийн сонгон шалгаруулалт болон ажиллагааны явцад хяналт тавих үүргийг “эрх бүхий этгээд”-д ногдуулсан. Энэ бүх зохицуулалт нь арбитрын үйл явцыг үр дүнтэй, шударга, хараат бус явуулах үндэс болдог.

Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай бусад орны стандарт

19. БНХАУ-ын Арбитрын тухай хууль нь арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаар тодорхой стандарт, шаардлагыг тогтоосон бөгөөд эдгээр нь арбитрын үйл явцын шударга, хараат бус байдлыг хангахад чиглэгддэг.

Арбитрчид тавигдах шаардлагыг тус хуулийн 13-р зүйлд тодорхойлсон бөгөөд үүнд арбитрч нь хууль эрх зүйн мэдлэгтэй, мэргэжлийн ур чадвартай, ёс зүйтэй, ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлагатай гэж заасан байдаг.

20. 13-р зүйлд зааснаар арбитрч нь дараах үндсэн шалгуурыг хангах ёстой. Үүнд, хууль эрх зүйн мэргэжилтэн эсвэл олон жилийн туршлагатай хуульч байх; хууль, арбитрын практикийн талаар мэдлэг, туршлагатай байх; ашиг сонирхлын зөрчилгүй, талуудын аль нэгэнд давуу байдал олгосон эсвэл нөлөөлөх ямар нэгэн холбоо хамааралгүй байх зэрэг багтана.
21. Арбитрчийн ёс зүйг хянах, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх үүргийг арбитрын комисс хариуцдаг. Арбитрын тухай хуулийн 34-р зүйлд зааснаар хэрэв талуудын аль нэг нь арбитрчийн хараат бус байдалд эргэлзэж, ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл арбитрын комисс уг асуудлыг шалгаж, шаардлагатай бол тухайн арбитрчийг өөрчлөх эрхтэй. Энэ зохицуулалт нь арбитрчийн ёс зүй, хараат бус байдлыг баталгаажуулж, талуудын итгэлийг хангах зорилготой.
22. Цаашлаад, арбитрын холбоодын дүрмийг мөн дурдаж болно.БНХАУ-ын арбитрын холбоод нь арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийг хянах үүргээ хэрэгжүүлэхдээ өөрсдийн үйл ажиллагааны дүрэм, журмуудад энэ талаарх зохицуулалтыг багтаадаг. Тухайлбал, Хятадын олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комисс болон бусад томоохон арбитрын байгууллагууд арбитрчийг сонгон шалгаруулах, томилох, тэдний хараат бус байдлыг баталгаажуулах нарийвчилсан дүрэмтэй.
23. СИЕТАС-ын Арбитрын дүрэм-д арбитрчийн хараат бус байдал, ёс зүй, мэргэжлийн ур чадварын талаар тусгайлан заасан байдаг. Жишээлбэл, уг дүрэмд арбитрч нь талуудын аль нэгэнд давуу байдал олгох аливаа үйлдлээс зайлсхийх, арбитрын процессын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн бол даруй мэдэгдэх үүрэгтэй. Мөн арбитрч нь талуудын итгэлийг алдахуйц аливаа зан авир гаргасан тохиолдолд СИЕТАС-ын ёс зүйн хорооны хяналтад орж, шаардлагатай тохиолдолд хариуцлага хүлээдэг.
24. Эдгээр зохицуулалтууд нь арбитрын комиссуудын үйл ажиллагааны гол зарчим болох шударга, хараат бус байдлыг хангахад чиглэгдсэн бөгөөд БНХАУ-ын Арбитрын тухай хууль-ийн ерөнхий шаардлагыг практикт хэрэгжүүлэхэд дэмжлэг

үзүүлдэг. Иймд арбитрын комиссууд нь арбитражийн ёс зүйн стандартыг хянах, сахиулах замаар талуудын маргааныг үр дүнтэй, шударга шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж ажилладаг.

Оросын Холбооны Улс

1. ОХУ-д арбитрын үйл ажиллагаа хоёр тусдаа системээр дамжуулан хэрэгжүүлдэг байна. Нэг нь Арбитрын шүүх (Арбитражный суд), нөгөө нь Арбитр (Арбитраж) байна. Утгын хувьд төстэй ойролцоо агуулгатай боловч системийн хувьд хоёр тусдаа систем байна Арбитрын шүүх нь тус улсын шүүхийн тогтолцоонд хамаардаг илүү дагнасан шүүхийн эрх хэмжээтэй байгаа бол Арбитр нь сонгодог арбитрын байгууллагын чиг үүрэгтэй байв. Нэр томьёо болон зохицуулалтын хувьд ч арбитрын шүүх нь илүү шүүхийн тогтолцоонд хамаарч, эрх хэмжээ нь шүүхийн тогтолцоотой уялдсан байв. Харин арбитр нь илүү ЮНСИТРАЛ-ын загвар хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг институт байна. Иймд ОХУ-ын зохицуулалт нь хоёр тусдаа чиглэлтэй, төвөгтэй, нарийн систем байсан. Сонгодог арбитраа ОХУ-д гуравдагч шүүх ч гэж нэрлэсэн байх жишээтэй.
2. ОХУ-д Арбитрын үйл ажиллагаа нь Арбитрын тухай 2015 оны хууль, Худалдааны арбитрын тухай хууль¹⁹, Арбитрын үйл ажиллагааны кодекс²⁰ болон Иргэний процессын кодексийн дагуу зохицуулагддаг. Мөн ОХУ-д тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зохицуулалт үйлчилдэг байна.
3. Арбитрын процессын тухай хуулийн 1 болон 5 дугаар зүйлд нь зааснаар тус хуулийн үйлчлэх хүрээ нь бизнесийн болон эдийн засгийн маргааныг хянан шийдвэрлэх гэж заасан онцлогтой бөгөөд энэ чиглэлийн маргаан шийддэг дагнасан шүүх гэж хэлж болно. 2002 онд батлагдсан Арбитрын процессын тухай хуульд арбитрын ажиллагааг эхлүүлэх, хэрэг хянан шийдэх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг агуулдаг. Энэ хуулийн зорилго болон зохицуулалтыг харахад илүү дагнасан шүүхийн агуулгатай бөгөөд сонгодог арбитрын байгууллагаас ялгаатай байв. Эдгээр шүүх нь гадаадын орнуудад дагнан үйл ажиллагаа явуулдаг худалдааны болон эдийн засгийн тусгай шүүхийн

¹⁹ https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_191301/ea6152e9068c49297ce8e3244874b570d6bf08bc/

²⁰

<https://www.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc&base=LAW&n=482731&dst=100001#wJ25bYUQuB4lw5fl>

үйл ажиллагаатай төстэй байна. Мөн эдгээр шүүх нь улсын байгууламж байдаг бол арбитрыг хувь этгээд, компани, холбоо байгуулдаг байна.

4. Арбитрын шүүх болон арбитрын өөр нэг ялгаатай зүйл нь Арбитрын шүүхэд харьяаллын дагуу хэн ч хандаж болох бол, арбитраг зөвхөн арбитрын хэлэлцээрт үндэслэж ханддаг байна.
5. ОХУ-д Арбитрын шүүхийн төрөл, онцлогийг зохицуулсан 1995 оны Арбитрын шүүхийн талаар Холбооны хууль²¹ үйлчилдэг юм. Тус хуулийн 3 дугаар зүйлд зааснаар ОХУ-д анхан шатны болон давах арбитрын шүүх муж, хязгаар, тойрог, автономит тойрогт болон төрөлжсөн арбитраг ажиллаж болох юм байна. Тус улсын нэг онцлог нь арбитрын шүүхийн анхан шатны хэмжээнд болон давах хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой байдлаар зохицуулсан байв. Арбитрын шүүх нь улсын шүүхэд харьяалагдахаас бусад хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй бөгөөд ерөнхий хүрээ нь бизнесийн болон эдийн засгийн маргаанаар хязгаарлагдсан байна.
6. Бизнесийн болон эдийн засгийн маргаан гэдэгт Арбитрын процессын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нь зааснаар иргэний эрх зүйн харилцаанаас болон захиргааны эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргааныг багтаасан байв.
7. ОХУ-д бусад орны зохицуулалттай ялгаатай харьяаллыг мөн тогтоосон байх онцлогтой. Холбогдох хуулийг судлахад нэр нь арбитрын шүүх гэсэн боловч үндсэндээ бол гадаад орнуудад байдаг худалдааны эсхүл эдийн засгийн шүүхээ арбитрын шүүх гэж нэрлэсэн байв. Тухайлбал Арбитрын процессын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар бизнесийн болон эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй маргааныг шийдвэрлэхдээ дампуурал; хуулийн этгээдийг байгуулах, хувьцаа, үүсгэн байгуулагчдын хоорондын маргаан, гүйцэтгэх удирдлагыг томилох, холбогдох үнэт цаасны маргаан, зохион байгуулалт, хурлын холбоотой маргаан; хувиараа аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзан талаар маргаан; үнэт цаасны бүртгэл, хадгалахтай холбоотой маргаан, төрийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбоотой

маргаан, оюуны өмчийг хамгаалах маргаан, арилжааны болон эдийн засгийн үйл ажиллагааны албан нэр хүндийг хамгаалах маргааныг шийдэж болно гэжээ.

8. ОХУ-ын арбитрын шүүхийн тухай хуулийн өөр нэг онцлог нь захиргааны болон нийтийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй эдийн засгийн маргааныг шийдэх эрх хэмжээний талаар 29 дүгээр зүйлд нь заасан байдаг. Тухайлбал, оюуны өмчийн эрхтэй холбоотой гүйцэтгэх засаглалын эрх зүйн хэм хэмжээний актын талаар маргаан, бизнесийн болон эдийн засгийн үйл ажиллагаанд хамаарах төрийн байгууллагын хэм хэмжээний бус актын талаар маргаан, арбитрын шүүхэд хамаарах захиргааны зөрчилтэй холбоотой маргаан, төлбөр хураамжтай холбоотой маргаан, арбитрын шүүхэд хамаарах бусад маргаан нь харьяалагдаж болох талаар заажээ. Ер нь Арбитрын шүүх нь нийтийн эрх зүйн холбоотой нэлээд олон маргааныг шийдэх эрх хэмжээтэй байдаг нь бусад орны зохицуулалтаас ялгаатай, дээр дурдсан шүүхийн тогтолцоонд хамаардаг онцлог шүүх байна.
9. ОХУ-д төрөлжсөн арбитрын шүүхэд зөвхөн Оюуны өмчийн арбитрын шүүх байгуулагдах талаар хуульд нь заасан байдаг. Дээр дурдсанаар ОХУ-д арбитрын шүүхийн талаар Арбитрын шүүхийн тухай 1995 оны Хуулиар зохицуулсан байдаг. ОХУ-д дараах арбитрын шүүх байдаг:
 - a. Тойргийн буюу кассацийн шатны арбитрын шүүх
 - b. Арбитрын давах шатны шүүх
 - c. Республик, хязгаар, орон нутаг, хотын, автономит тойргийн анхан шатны арбитрын шүүх
 - d. Төрөлжсөн арбитрын шүүх ²²
10. Оюуны өмчийн шүүхийг 2012 онд байгуулсан бөгөөд тус шүүх нь анхан шатны журмаар оюуны өмчийн эрхийг хамгаалах хүрээнд нэхэмжлэгчийн хууль ёсны эрх ашгийг хөндсөн холбооны хэмжээний гүйцэтгэх засаглалын хэмжээний актын талаар маргаан, эрхээ хамгаалах, хууль бус үйл ажиллагааг зогсоох, нууц бүтээлийн талаар патент олгох талаар шийдвэрийн талаар маргаан, хуулийн этгээдийн тусгай эрх, бараа, ажил, үйлчилгээний эрхийг олж авсантай холбоотой

²² https://arbitr.ru/materials/ojfederal_nixjarbitrazhnixjsudax

үйл ажиллагааг шударга бус өрсөлдөөний үйл ажиллагааг гэж үзсэн монополын эсрэг холбооны газрын шийдвэрийн талаар маргаан, патентын эрхийн маргаан зэргийг хянан шийдвэрлэх эрхтэй байна.

11. ОХУ-д Спортын арбитрын үйл ажиллагааг тус улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх тушаалаар 2009 онд батлагдсан журмаар зохицуулдаг. Мөн 2017 онд Спортын арбитрын дүрэм тус байгууллагын хүрээнд батлагдсан байдаг.²³ Тус Спортын үйл ажиллагааны журмын 3 -т заасны дагуу спортын холбоотой маргааныг спортын арбитр хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй. Мөн спорт дахь допингийн эсрэг ЮНЕСКО-ийн 2005 оны Конвенци, мөн Допингийн эсрэг Олон улсын агентлагийн Дэлхийн допингийн эсрэг 2003 оны Кодекс заасны дагуу Спортын арбитр нь давах журмаар допингийн журам зөрчсөн талаар маргааныг авч хэлэлцдэг.
12. Спортын арбитрт зөвхөн талуудын харилцан тохиролцсон хэлэлцээрт үндэслэж маргаан шийдвэрлэдэг. Орос хэлээр тус хэлэлцээрийг гуравдагч хэлэлцээр ба давах хэлэлцээр (третейское соглашение, апелляционное соглашение) игэж ангилсан байна.²⁴
13. ОХУ-ын Иргэний процессын хуульд нь гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх талаар Бүлэг 45-д зохицуулсан байдаг.²⁵
14. ОХУ-д Арбитрын шүүхийн үйл ажиллагааг хуульд заасан субъектүүд хэрэгжүүлдэг бөгөөд арбитрын шүүхийн шийдвэрийг давж заалдах журмыг мөн Арбитрын процессын хуульд нь заасан байдаг бөгөөд энэ талаар гомдлыг давж заалдах арбитрын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ гэжээ (АпХ-ийн 230-р зүйл). Эдийн засгийн болон бизнесийн маргааны талаар гарсан арбитрын шийдвэрийн талаар гомдлыг тухайн шийдвэр гарсан газар гаргаж болно гэж 230 дугаар зүйлийн 230.2-дахь хэсэгт нь заасан байна. .
15. ОХУ-д прокурор нь мөн Арбитрын процессын хуулийн 52 дугаар зүйлд заасан маргаантай холбоотойгоор ОХУ-ын төрийн байгууллагын хууль ёсны эрх ашгийг

²³ https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_163401/56fe65b6b8f100f4e6249a7e0b59e2b27cd50817/
²⁴

<https://www.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc&base=LAW&n=163401&dst=100015#CNOSbYU70f3FMgR1>

²⁵ https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/578ee39ae9789b871505d97f97dc58694abf50c0/

хөндөж буй болон холбогдох байгууллагын оролцоогүй гаргасан арбитрын шийдвэрийн талаар гомдол гаргаж болох талаар 230.3-т нь заасан байдаг. Энэ гомдлыг мөн шийдвэр гаргасан газрын давж заалдах арбитрын шүүхэд гаргаж болох талаар заажээ.

Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт

16. ОХУ-д байнгын арбитрын шүүхийг Арбитрын шүүхийн тухай Холбооны хуулийн дагуу байгуулахыг зөвшөөрдөг бөгөөд өнөөдрийн байдлаар 4 түвшний арбитрын шүүх байдаг гэжээ.²⁶
 - a. Нэгдүгээр шатанд- анхан шатны арбитрын шүүх
 - b. Хоёрдугаар шатны -давж заалдах шатны арбитрын шүүх
 - c. Гуравдугаар шатны шүүх- 10 тойргийн шүүх, кассацийн журмаар хэрэг хянана
 - d. Дээд Шүүх
17. Мөн тусдаа худалдааны арбитрын тогтолцоо тус улсад байгаа бөгөөд ОХУ-ны Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд олон улсын худалдааны арбитр, орос хэлээр “Арбитраж” гэж байна. Уг арбитр нь ЮНСИТРАЛ-ын загвар хууль, журамд нийцүүлэн илүү олон улсын арилжааны арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлдгээрээ дээр дурдсан ОХУ-ын шүүхийн тогтолцоонд багтдаг Арбитрын шүүхээс тусдаа систем юм.
18. Байнгын бус арбитрын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй боловч Арбитрын тухай 2015 оны хуульд гуравдагч шүүх гэдэгт ганцаарчилсан арбитр болон бусад арбитрчийг багтаана гэжээ.
19. ОХУ-д арбитрын шүүхийн талаар тусгайлсан зохицуулалт тогтоож, шүүх байгуулах болон арбитрын шүүхийн төрлийг заасан байдаг тул байнгын бус арбитрч хэрхэн арбитрын ажиллагаанд оролцох нь тодорхойгүй байна
20. ОХУ-д Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд нь Худалдааны/арилжааны олон улсын арбитр (Международный коммерческий арбитраж) байгуулагдан

²⁶ https://amuras.arbitr.ru/about/arb_syst

ажилладаг байна. Тус арбитр нь 90 жилийн түүхтэй бөгөөд 10,000,000 орчим хэрэг хянан шийдвэрлэсэн гэжээ. Энэхүү арбитр нь олон улсын арилжааны маргааныг шийдэх эрх хэмжээтэй юм. Тус арбитрын үйл ажиллагааг 1993 онд батлагдсан Олон улсын арилжааны арбитрын тухай хуулиар зохицуулдаг.

21. 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн тус арбитр нь Худалдаа аж үйлдвэрийн танхимын гуравдагч шүүхийн эрх хэмжээ болон Спортын арбитрын эрх хэмжээг залгамжлан захиргааны зохион байгуулалтыг хийх эрхтэй болсон байна. Тус арбитрт худалдааны, арилжааны болон гэрээний болон гэрээний бус иргэний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй олон улсын маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй юм. Тус байгууллагын веб сайтын мэдээллийг үндэслэхэд дотоодын, компанийн, зарим нөхцөлд захиргааны болон спортын маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй гэжээ.
22. Дээрх зүйлийг үндэслэхэд 2015 оны Арбитрын тухай хуульд заасны дагуу тус улсад худалдааны арбитрыг байгуулж болох бөгөөд энэ хуулиар худалдааны буюу арилжааны арбитрыг зохицуулдаг, мөн тус арбитрт зөвхөн арилжааны олон улсын ба олон улсын бус маргааныг шийдвэрлэх боломжтой юм. 2017 оноос хойш харин компанийн болон спортын маргаан хянан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх талаар нэмж зохицуулсан байв.

Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт

23. ОХУ-ын Арбитрын шүүхийн тухай хуульд зааснаар арбитрын ажиллагаатай холбоотой маргааныг тухайн шатны арбитрын шүүх өөрөө шийдвэрлэдэг онцлогтой, мөн тус шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах арбитрын шүүхэд шийдүүлдэг онцлогтой байв. ОХУ-ын Арбитрын шүүхийн тухай хуулийг үндэслэхэд ОХУ-д бизнесийн болон эдийн засгийн агуулгатай маргааныг Арбитрын процессын тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэдэг юм.
24. Худалдааны буюу арилжааны маргааныг хянан шийдвэрлэх танхимын дэргэдэх арбитр нь өөрийн дүрэм журмаа баталсан байдаг.²⁷

²⁷ <https://mkas.tpprf.ru/ru/materials/>

25. ОХУ-ын Олон улсын худалдааны арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам нь ЮНСИТРАЛ-ын загвар журамтай илүү нийцсэн агуулгатай бөгөөд Танхимын дэргэдэх уг арбитрын хороо нь арбитрын үйл ажиллагаатай холбоотой зарим асуудлыг шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл тус хороо нь шүүхээр шийдэх асуудлыг өөрөө шийддэг онцлогтой байна. Тухайлбал тус хороо нь арбитрч томилох, арбитрчаас татгалзах маргааныг таслах эрхтэй.
26. Нөгөө талаар 2015 оны Арбитрын тухай хуульд мөн шүүхээр шийдүүлэх, шүүхийн туслалцаа авах эрхийг нь хязгаарлаагүй байв.

Мэргэжлийн холбоо, хяналт тавьдаг байгууллага

27. ОХУ-д мөн бусад улсын адил арилжааны арбитрын үйл ажиллагааг хөгжүүлэх, хуульд нийцүүлэхэд нь хяналт тавьдаг Арбитрын ассоциаци байгуулагдан ажилладаг.
28. Арбитрын ассоциаци нь 2013 оноос байгуулагдаж, гуравдагч болон арилжааны арбитрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх болон сургах, эрх зүйн зохицуулалтыг боловсонгүй болгох чиглэлээр ажиллаж байна.²⁸

Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай бусад орны стандарт

29. Арбитрын тухай 2015 оны хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар арбитрчийг талууд сонгож томилдог ерөнхий зарчим үйлчилнэ. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар арбитрч нь хууль зүйн дээд боловсролтой, харин нэгээс дээш хүний бүрэлдэхүүнээр хэрэг шийдэж байгаа бол хуульч биш хүнийг томилж болдог. Арбитрч нь 25 нас хүрсэн, ял эдэлж байгаа хүн байж болохгүй, мөн давхар шүүгч, өмгөөлөгч, нотариат, мөрдөн байцаагч, прокурор, эсвэл хууль сахиулах байгууллагын алба хашиж болохгүй гэжээ. Мөн 11.6.11-т холбооны

²⁸ <https://arbitration.ru/arbitration-association/>

хуулиар арбитрчаас сонгогдож болохгүй албан тушаалтан мөн арбитрч болж болохгүй гэж заасан байна.

30. ОХУ-д үйлчилж буй арбитрын тухай хууль тогтоомжийн дагуу арбитрч нь хараат бус болон хамааралгүй байх ёстой юм. Худалдаа аж үйлдвэрийн танхимын баталсан арбитрчийн хараат бус болон хамааралгүй байдлын журамд заасны дагуу арбитрч нь тухайн хэрэгт хамааралгүй, хараат гэсэн мэдүүлгээ гаргаж өгөх үүрэгтэй. Тус дүрэм нь олон улсын стандартыг нэвтрүүлэх зорьсон гэдгийг тэмдэглэсэн бөгөөд ОХУ-д арилжааны арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагуудад хамаарна гэжээ.
31. Харин шүүхийн тогтолцоонд хамаардаг Арбитрын шүүхийн хувьд шүүхийн тухай хууль үйлчилнэ. Тухайлбал, ОХУ-ын Шүүхийн тухай 1992 оны хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ОХУ-д хууль зүйн дээд боловсролтой, эрүүгийн ял шийтгэлгүй, тухайн улсын иргэн, сэтгэцэд нөлөөлөх бодисын хамааралгүй, шүүгчийн эрх хэмжээг хэрэгжүүлэхэд саад болох өвчингүй 40 нас хүрсэн, 15 жилийн туршлагатай ОХУ-ын иргэн байна гэж заасан байна. Харин тус зүйлийн 4- т зааснаар арбитрын шүүхийн шүүгчээр 25 нас хүрсэн, хууль зүйн салбарт 5 жил ажилласан туршлагатай иргэн байж болно гэжээ.

III. Харьцуулалтад хамаарах Монгол Улсын зохицуулалт

A. Арбитрын маргааны харьяалал болон төрөлжсөн арбитрын зохицуулалт

1. Монгол Улсын Арбитрын тухай хуульд “*шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ*” хэмээн заасан.²⁹ Ингэхдээ аливаа маргааны төрлийг эдийн засгийн шинж чанартай, эсхүл бүх төрлийн арбитр зэргээр тодорхой зааж өгөөгүй бөгөөд үүнээс үүдэн мэргэшлийн холбоодод харьяалагддаг төрөлжсөн арбитр нь тус хуулийн хамрах хүрээнд багтах боломжит нөхцөл байдал үүсэж байна.
2. Энэхүү судалгааны хүрээнд авч үзсэн орнуудад Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнууд болох АНУ болон Их Британи улсад Арбитрын тухай хуулийн үйлчлэх

²⁹ Арбитрын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

хүрээнд гол төлөв арилжааны маргаан эсхүл тус хуульд хамаарахгүй харьяаллыг тусган зааж зохицуулсан байна. Эдгээр орнуудад төрөлжсөн арбитрын тогтолцоо нэлээд хөгжсөн байсан бөгөөд тусгай мэргэжлийн холбооны дэргэдээ төрөлжсөн маргааныг шийдэх, хөдөлмөрийн, барилгын, оюуны өмчийн арбитрын дүрмийг тогтоосон байдаг. Спортын арбитр нь спортын холбооны дэргэд байж, өөрийн гэсэн онцлог зохицуулалттай байна.

3. ОХУ- Арилжааны буюу Худалдааны арбитрын тухай 2015 оны хуульд нь зөвхөн арилжааны маргааныг авч хэлэлцээр хязгаарласан байв. ОХУ-ын нэг онцлог нь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх арбитрын холбоо нь арилжааны маргаан, мөн спортын болон компанийн маргааныг шийдэх буюу төрөлжсөн маргааныг шийдэх тусдаа тогтолцоог бий болгожээ
4. Харин Арбитрын тухай МУ-ын хуульд ЮНСИТРАЛ-ын загвар хуулийг үндэслэсэн боловч өөрийн хуульдаа түүний адил харьяаллыг арилжааны гэж хязгаарлаагүй, шүүхээр шийдэхгүй бөгөөд арбитраар хянан шийдвэрлүүлэх маргааныг өөртөө харьяалуулан авсан байна. Тухайлбал өөрийн гэсэн онцлогтой спортын, хөдөлмөрийн маргааныг энэ буюу арилжааны зориулалттай ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлсэн Арбитрын тухай хуулиар зохицуулж байна. .
5. Практикт ч энэ хэрэгжиж, жишээ нь Спортын арбитр нь 2017 оны ЮНСИТРАЛ-ын Загварын арбитрын тухай хуульд нийцүүлэн зохицуулагдаж байна. Гадаад орнуудын зохицуулалтыг харьцуулахад спортын болон хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагааг ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн дагуу баталсан Арбитрын тухай хуулиар зохицуулж буй улс судалсан орнууд дунд алга байна.

Б. Байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, процессын ялгаа

1. Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-дэх хэсэгт арбитрыг байнгын болон түр байна хэмээн заасан.³⁰ Мөн түр арбитрыг талуудын тохиролцсон журмын дагуу байгуулна гэжээ.³¹ МУ-ын Арбитрын тухай хуулийн зохицуулалт нь байнгын болон

³⁰ Арбитрын тухай хуулийн 7.1-р зүйл

³¹ Арбитрын тухай хуулийн 7.5-р зүйл

байнгын бус арбитрагт хамаарах агуулгатай хэдий ч практикт байнгын бус арбитраар маргаанаа хянан шийдүүлж байгаа тохиолдол бага байна. Барууны орнуудад түгээмэл болсон энэхүү практикт Монголд түгээн дэлгэрэхгүй байгаа нь уламжлалт эрх зүйн хандлага, заавал байнгын институтээр хэргээ хянан шийдүүлэх сонирхолтой ч холбоотой байж болзошгүй. Хэдий тийм боловч Монгол Улсын шүүхээс тусламж авах, шийдвэрийг Монгол Улсад хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөлд байнгын бус арбитрагын зохицуулалтыг хөгжүүлэх нь чухал гэж үзэж байна.

2. Арбитрагын тухай Монгол Улсын хууль байнгын болон байнгын бус арбитрагын талаар танилцуулахад,

АтХ-ийн 7-р зүйлд:

7.1. Арбитраг нь байнгын, эсхүл түр байж болно.

7.2. Байнгын арбитраг нь арбитрагын ажиллагааны дүрэмтэй байна. Байнгын арбитраг нь энэ хуулийн 13.4, 16.1-д заасан хүсэлтийг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болно.

7.3. Монгол Улсад байнгын арбитрагыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно.

7.4. Энэ хуулийн 7.3-т заасан байнгын арбитраг нь арбитрагын ажиллагааг явуулах байр, хүний нөөцтэй байна.

7.5. Түр арбитрагыг талуудын харилцан тохиролцсон журмын дагуу байгуулна

3. Гадаадын арбитрагын тухай хуулийг судлан авч үзэхэд байнгын болон байнгын бус гэж ангилахгүйгээр арбитрагын үйл ажиллагааг нэгдсэн нэг хуулиар зохицуулж, харин төрөлжсөн арбитрагын хувьд холбогдох журмаар нь зохицуулсан байна. Байнгын бус арбитраар хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог АНУ, Их Британи, ОХУ-д тусгайлан зохицуулаагүй, хуульд нь байнгын болон байнгын бус арбитрагт хамаарах байдлаар зохицуулжээ.
4. Эдгээр орнуудын арбитрагын үйл ажиллагааны талаар зохицуулалтыг авч үзэхэд, байнгын арбитрагын байгууллагууд нь байнгын бус арбитраар маргаан шийдүүлэхэд нь захиргааны тусламж үзүүлж болох талаар зохицуулж, тусгайлсан журам баталсан байдаг. МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитраар түр арбитрагт

дэмжлэг үзүүлэх тухай дүрмийг баталсан нь дэлхийн нийтийн хандлагатай нийцэж байна гэж хэлж болно.

5. Олон улсын арилжааны болон бусад арбитрын төрлийг байнгын болон байнгын бус хэмээн ангилах нь стандарт зохицуулалт бөгөөд өөрсдийн гэсэн онцлогтой байна. Харин Монгол Улсын дотоодын зохицуулалтад байнгын арбитрыг тодорхой зохицуулсан боловч байнгын бус арбитрын төдийлөн онцлон зохицуулж чадаагүй байна. Үүний улмаас, маргааны талууд байнгын бус арбитраар маргаан шийдвэрлүүлэх нь бага байх боломжтой. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын хувьд, АТХ-ийн 7-р зүйлд тусгагдсан арбитрын төрлүүдийн нэг болох байнгын бус арбитрын ойлголт, зохицуулалтын онцлог зэрэг нь хангалтгүй байгаа бөгөөд үүний улмаас практикт хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байх юм. Иймд, Арбитрын тухай хуульд байнгын бус арбитраар маргаан шийдвэрлүүлэхэд анхаарах зохицуулалтуудыг тусгаж өгөх нь зүйтэй юм. Үүнд тухайлбал, гэрээний чөлөөт байдлын зарчмыг үндэслэн үүсгэн байгуулагдах түр арбитрын процессын журмын хуульд нийцсэн байдал, мэргэшсэн арбитрчийн тодорхойлолт болон шийдвэр биелэлтийг хангах зохицуулалтууд багтах боломжтой.

В. Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, холбоодын зохицуулалт

1. Монгол Улсад арбитрын үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих нэгдсэн тогтолцоо байдаггүй. Арбитрын тухай 2017 оны хуульд заасны дагуу байнгын арбитрын байгууллага байгуулж болох талаар заасан байдаг тул өнөөдөр улсын хэмжээнд МХАҮТ-ын дэргэд Олон улсын арбитр, Нийслэлийн танхимын дэргэд Улаанбаатар хотын арбитр, Спортын олон улсын арбитр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Эдгээр арбитр нь өөр өөрийн холбоо, танхимын хүрээнд дүрэм журмаа баталсан байдаг.
2. Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн 2024 оны судалгааны үр дүнг үндэслэхэд эдгээр арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, журам нь Арбитрын тухай хуульдаа бүрэн нийцээгүй, зарим нь бүр зөрчилдөж, арбитрын үйл ажиллагааны амин сүнс зохицуулалтаасаа ялгаатай байв. Энэ нь тухайн холбогдох төрөлжсөн арбитрын онцлогтой холбоотой байх нь ойлгомжтой.

3. Бусад орны жишээг харахад Арбитрын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохицуулдаг Арбитрын холбоо нэлээд түгээмэл болж, эдгээр холбоо нь арбитрын үйл ажиллагааг хөгжүүлэх, тогтолцоог нь сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулж байна. Харин манай улсад ийм төрлийн байгууллага байхгүй, арбитр бүр дор дороо өөрийн дүрэм, журмаа боловсруулаад явж байна.

Г. Арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, эрх үүргийн хязгаарлалт

1. Монгол Улсын Арбитрын тухай хуульд “эрх бүхий этгээд”-ийг тодорхойлоогүй орхисон бөгөөд арбитрын үйл ажиллагааны явцад үүссэн аливаа маргааныг шүүхээр шийдвэрлэхээр зохицуулсан. Харин зарим орнууд “эрх бүхий этгээд”-д шүүхээс гадна мэргэшсэн холбоод, арбитрын байгууллагыг оруулдаг бөгөөд талууд тохиролцсон тохиолдолд эрх бүхий этгээд арбитрчийг томилох зэрэг шийдвэрийг гаргах эрхтэй.
2. Гадаад орнуудын холбогдох зохицуулалтыг авч үзэхэд Байнгын арбитрын үйл ажиллагаа явуулдаг арбитрын байгууллагууд хэрэг хянан шийдвэрлэх өөрийн дүрмээ баталж, арбитрын үйл ажиллагаатай холбоотой, процессын холбогдолтой маргааныг дэргэдэх эрх бүхий этгээд, жишээ нь ОХУ-д эрх бүхий байгууллага болох Хорооны хэмжээнд шийдвэрлэх талаар зохицуулсан байна. Харин АНУ болон Их Британийн арбитрын тухай хуульд нь сонирхсон тал нь шүүхэд хандаж шийдүүлж болох талаар заасан байдаг ч эдгээр орнуудад Арилжааны арбитрыг ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэхийг эрмэлзсэн байдаг тул ЮНСИТРАЛ-ын загвар хуульд заасанчлан арбитрын ажиллагаатай холбоотой асуудлыг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх боломжтой байдаг бөгөөд холбогдох төрөлжсөн арбитрын дүрэмдээ энэ талаар заасан байдаг.
3. Монгол улсын хувьд эрх бүхий этгээдийг тодорхойлоогүй улмаас арбитрын практикт арбитрын ажиллагаатай холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх хандлага хадгалагдсаар байна. Иймд бусад орны жишгээр байнгын арбитрын дүрмээр холбогдох арбитрын дэргэдэх эрх бүхий байгууллага шийддэг болсноор арбитрын ажиллагаа түргэн шуурхай хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Д. Арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тухай зохицуулалт

1. Монгол Улсын Арбитрын тухай хуульд арбитрчийг татгалзан гаргах үндэслэлд талуудын тохиролцсон мэргэжлийн ур чадварт нийцээгүй, эсхүл арбитрчийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл үүссэн тохиолдлыг багтааж үздэг.³² Бусдаар ёс зүй, ур чадвартай холбогдох зохицуулалт байхгүй. Үүнийг арбитрын байгууллага, мэргэжлийн холбоод дотоод дүрмээрээ зохицуулдаг байна. МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитр нь арбитрчийн ёс зүйн дүрмээ баталж зохицуулсан байдаг
2. Арбитрын тухай хуульд арбитрчид тавигдаж байгаа шаардлага нь бусад орны зохицуулалттай төстэй байна. Гадаадын орнуудад арбитрч нарт хууль зүйн боловсролтой байх, хараат бус байх, салбартаа мэргэшсэн байх, мөн бүрэлдэхүүнтэй хэргийг шийдвэрлэж байгаа бол заавал хууль зүйн боловсролтой байхыг шаарддаггүй байна. Иймд олон улсын энэ жишигт нийцүүлэн хуульдаа өөрчлөлт оруулах нь зүйтэй.
3. Харин байнгын арбитрын байгууллагууд арбитрч нарт тавигдах шаардлага, талуудаас хараат бус байдлыг хангах шалгах шалгуур, арбитрч нарт хориглох үйл ажиллагааг журмаар зохицуулдаг байна. Ингэхдээ арбитраар томилогдох үеийн мэдүүлэг болон томилогдсоны дараах үүргийг нарийн зааж өгсөн байв.

³² Арбитрын тухай хуулийн 14 дугаар зүйл

IV. Дүгнэлт

Арбитрын маргааны харьяалал, байнгын болон байнгын бус арбитрын зохицуулалт, арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, арбитрын ажиллагааны “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолт, арбитрчийн мэргэжлийн ур чадвар болон ёс зүйтэй холбоотой бусад орны зохицуулалтуудыг судалж үзээд дараах дүгнэлтийг гаргалаа.

1. Гадаад орнуудад арбитрын маргааны харьяаллыг зааглаж, харьяаллаас нь хамаарч тусдаа зохицуулалт хийж, арбитрын ажиллагааг ангилсан байна. Арбитрын тухай ерөнхий хуульдаа харьяалагдах маргааныг заахдаа гол төлөв арилжааны болон эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй гэрээний болон гэрээний бус маргааныг багтаасан байв. Хари захиргааны, гэр бүлийн зэрэг зарим маргаануудыг арбитрын журмаар шийдвэрлэхийг хуулиар хориглодог нь нийтлэг байна.
2. Иймд Монгол улсад Арбитрын тухай хуульд хамаарах харьяаллыг тухайн хуулийн зорилгод нь нийцүүлэн тогтоож, 2017 оны Арбитрын тухай хуулийн үйлчлэх хүрээнд арилжааны маргааныг харьяалуулж, төрөлжсөн арбитрыг тусдаа хуулиар зохицуулах нь зүйтэй гэж дүгнэгдлээ. Ялангуяа энэ нь спортын арбитрын хувьд ялгаатай зохицуулалттай байж, спортын маргаан шийдвэрлэх тогтолцоог олон улсын арбитрын үйл ажиллагаатай уялдуулах ач холбогдолтой юм. Хөдөлмөрийн арбитрын хувьд мөн тусдаа зохицуулалт хийснээр Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой юм байна гэж дүгнэгдлээ.
3. Байнгын болон байнгын бус арбитрын талаар гадаад орнуудад арбитрын тухай хуульдаа нарийн зааглаж зохицуулаагүй нь нийтлэг байна. Гэхдээ зарим улсад байнгын бус буюу *ad hoc* арбитрыг шууд хориглож (Жишээ нь ОХУ-ын Арбитрын тухай хууль, 2015 он), зөвхөн байнгын арбитрын байгууллагын хүрээнд маргааныг хянан шийдвэрлүүлэхийг хуульчилсан байв. Манай улсын хувьд Арбитрын тухай хуулийг 2017 онд шинэчилж найруулахдаа байнгын бус буюу түр арбитрын тогтолцоог нэвтрүүлэх зорилго байсан тул энэ үзэл санаанд нь нийцүүлэн байнгын бус буюу түр арбитрын тогтолцоог дэмжиж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм байна гэж дүгнэгдлээ.
4. Одоогийн эрх зүйн тогтолцооны дагуу Монгол Улсад Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийг хянах ерөнхий чиг үүрэг ХЗДХЯ-д л байна. Гэтэл бусад орнуудад арбитрын хуулийг сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг хэрэгцээ шаардлагад

нийцүүлэх, хөгжүүлэхэд мэргэжлийн холбоод илүү голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Эдгээр байгууллагууд арбитрчийн хараат бус байдал, ёс зүйн талаар дүрэм журам боловсруулах, арбитрын байгууллагыг хөгжүүлэх, арбитрчийг мэргэшүүлэх, төрөлжсөн арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм журам боловсруулахад туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг байна. Гэтэл Монгол улсад ийм байгууллага байхгүй, арбитрын байгууллагууд нь хоорондоо холбоогүй, арбитрын салбарынхан хамтардаггүй байдал үүсээд байна. Иймд цаашид Монгол Улсад арбитрын холбоо байгуулах хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэгдлээ.

5. Арбитрын тухай хуульд болон ЮНСИТРАЛ-ын загвар хуульд заасан арбитрын ажиллагааны явцад маргаан болон асуудлыг таслах, арбитрт туслалцаа үзүүлэх шүүхийн ачааллыг бууруулж, “эрх бүхий этгээд”-ийг хуульд илүү тодорхойлж, байнгын арбитуудад зарим асуудлыг заавал шүүхэд хандуулахгүйгээр өөрсдөө шийдэх эрхийг олгох боломжтой юм байна гэж дүгнэгдлээ. Жишээлбэл, арбитрчийг томилох, татгалзах болон бусад арбитрын ажиллагааны явцад гарсан асуудлыг эрх бүхий этгээд шийдэхийг зөвшөөрдөг бөгөөд гадаад орнууд энэ боломжийг түгээмэл ашигладаг байна.
6. Арбитрын харьяаллыг зөв тогтоосноор арбитраар хэрэг хянан шийдвэрлэх тоог нэмэгдүүлэх, шүүхийн ачааллыг бууруулах ч боломжтой гэж үзэж байна.
Ялангуяа, гадаад орнуудтай адил манай улсад худалдааны болон эдийн засгийн дагнасан шүүх байхгүй байгаа энэ нөхцөлд арбитрын шүүхийг илүү дэмжиж, эрх зүйн зохицуулалтыг тухайн арбитр бүрд нь тохируулан бий болгох нь чухал байна.
7. Энэхүү судалгааны хүрээнд авч үзсэн гадаад орнуудын зохицуулалтад арбитрчид тавигдах шаардлага нь нийтлэг бөгөөд арбитрчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн асуудалд өндөр шаардлага тавьдаг. Арбитрч нь хуулийн мэдлэгтэй, тухайн маргаанд туршлагаараа хувь нэмэр оруулах чадвартай, ёс зүйн зөрчилгүй, хараат бус байх ёстой. Мөн насны хувьд 25 нас хүрсэн байхыг шаарддаг байна.

Дээрх судалгааны үр дүн болон дүгнэлтийг үндэслэж, дараагийн бүлэгт нэмэлт өөрчлөлтийн зарим саналыг гаргасан болно.

V. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал

	2019 оны Арбитрын тухай хуулийн холбогдох заалт	Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал
Арбитрын харьяалал, төрөлжсөн арбитр		
2.1.	2.1. Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс бол энэ хууль үйлчилнэ.	2.2. Энэхүү хууль нь олон улсын болон дотоодын арилжааны шинж чанар бүхий арбитрын маргаанд үйлчилнэ.
9.1.	9.1. Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.	9.1. Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан арилжааны шинж чанар бүхий аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.
		9.2. Төрөлжсөн арбитрын хүрээнд маргаан шийдвэрлэх журмыг хуулиар зохицуулна.
Түр арбитрын талаар зохицуулалт		
3.1.	3.1. Арбитрын ажиллагаа гэдэгт байнгын, эсхүл түр арбитраас явуулж байгаа арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно.	
7.1.	7.1. Арбитр нь байнгын, эсхүл түр байж болно.	7.2. Түр арбитр нь байнгын арбитрын байгууллагаас арбитрын ажиллагаатай холбоотой захиргааны тусламж авч болно.
7.5.	7.5. Түр арбитрыг талуудын харилцан тохиролцсон журмын дагуу байгуулна.	
Эрх бүхий этгээдийг тодорхойлох талаар		

7.2.	7.2.Байнгын арбитр нь арбитрын ажиллагааны дүрэмтэй байна. Байнгын арбитр нь энэ хуулийн 13.4, 16.1-д заасан хүсэлтийг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болно.	7.2.1. Төрөлжсөн байнгын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмыг мэргэжлийн холбоод нь батлана.
7.3.	7.3.Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно.	7.3.Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа, үйлчилгээний болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, төрөлжсөн мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно.
13.4.1	13.4.1.арбитрын ажиллагаанд гурван арбитрч оролцох бол тал тус бүр нэг арбитрчийг томилох ба томилогдсон хоёр арбитрч гурав дахь арбитрчийг томилно. Арбитрч томилох тухай хүсэлтийг нөгөө талаас хүлээн авсан тал тийнхүү хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрчаа томилоогүй, эсхүл хоёр арбитрч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрчийг шүүх, эсхүл талуудын сонгосон арбитрын дүрэмд заасан, эсхүл талуудын тохиролцсон эрх бүхий этгээд /цаашид "эрх бүхий этгээд" гэх/ томилно;	13.4.1.1. Энэ хуулийн 7.2., 7.3., 13.4.1., 13.4.2., 16.1-р зүйлд заасан эрх бүхий этгээдийг байнгын арбитр дүрэмдээ зааж болно.
13.4.2	13.4.2. арбитрын ажиллагаанд нэг арбитрч оролцох үед талууд арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрчийг шүүх, эсхүл эрх бүхий этгээд томилно.	
16.1.	16.1. Арбитрч бодит шалтгааны улмаас, эсхүл хууль зүйн хувьд үүргээ	

	гүйцэтгэх боломжгүй болсон, эсхүл бусад шалтгаанаар үүргээ тасралтгүй гүйцэтгэж чадахгүй болсон үндэслэлээр өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, эсхүл талууд түүнийг үүргээс нь чөлөөлөхөөр тохиролцсон бол түүний бүрэн эрх дуусгавар болно. Эдгээр үндэслэл эргэлзээ төрүүлэхүйц байгаа бол аль нэг тал арбитрчийн бүрэн эрхийг дуусгавар болгох талаар шүүх, эсхүл эрх бүхий этгээдэд хүсэлт гаргаж болох бөгөөд хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэр эцсийн шийдвэр байна.	
Арбитрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага, мэргэжлийн холбоод		
	-	1. Байнгын болон түр арбитр нь арбитрын хөгжүүлэх, арбитрын маргаан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, арбитрчдийг мэргэшүүлэх, арбитрын хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор арбитрын холбоо байгуулж болно. 2. Арбитрын холбоог “Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай” хуулийн дагуу байгуулна.
Мэргэжлийн ур чадвар, ёс зүйн асуудлаар		
13.1.	13.1.Талууд дараахь шаардлагыг хангасан этгээдийг арбитрчаар томилж болно: 13.1.1.талуудын харилцан тохиролцож тогтоосон мэргэжил, ур чадварын тусгай шаардлагад нийцсэн;	
14.2.	14.2. Арбитрчийг гагцхүү хуулиар тогтоосон болон талуудын	

	тохиролцсон мэргэжил, ур чадварын шаардлагад нийцээгүй, эсхүл арбитрчийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа үндэслэлээр татгалзан гаргана.	
--	--	--